



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Мударга ёс, хөгжил дэвшилд

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,
АВЛИГЫН ЕРӨНХИЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛ 2023**

2024 он

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР НЬ

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, Авлигын эсрэг хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий **ХАРААТ БУС, БИЕ ДААСАН, ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГА** мөн.

Алсын хараа:

Шударга ёсны төлөө иргэдийн итгэл хүлээсэн байгууллага байна.

Уриа:

Шударга ёс,
хөгжил дэвшилд

Эрхэм зорилго:

Авлигатай тэмцэж,
шударга ёсыг тогтоон
хөгжил дэвшилд
хүргэнэ.

АГУУЛГА

НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	5
Нэг өгүүлбэрээр	6
Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	8
Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	32
Судалгаа, шинжилгээний ажил	39
Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах үйл ажиллагаа	43
Авлигын гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа	52
ХОЁР. АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	58
Гадаад судалгааны үр дүн	59
Дотоод судалгааны үр дүн	71
ГУРАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	77



МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлыг үүгээр мэдээлж байна.



НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагууд дунджаар **76.6** оноо авсан.

+2.7

Шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдын **74.6** хувь нь Монгол Улсад авлига түгээмэл, их түгээмэл гэж үзэж байна.

+6.6%

Улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн **3.96** гарсан.

-0.22

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн **3.90** гарсан.

-0.14

Хүүхдийн шударга байдлын түвшин **3.97** оноотой гарсан.

+0.01

Авлигын эсрэг сургалтад **35,573** иргэн, албан тушаалтныг хамруулсан.

-33%

Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан **63** шийдвэр, журам, дүрэм хянасан.

+21

+11

Хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй **44** шийдвэр, журам, дүрмийн талаар шаардлага хүргүүлсэн.

+25.7%

Нийт **3,749** гомдол, мэдээлэл хүлээн авсан.

+14.6%

Гэмт хэргийн шинжтэй **2,156** гомдол, мэдээлэл шалгасан.

+9.0%

1,670 гомдол, мэдээллийг бүртгэлд авч шалгасан.

+15.5%

Эрүүгийн хэрэгт **1,402** этгээд холбогдон шалгагдсан.

+42.7%

729 төрийн тусгай албан хаагч гэмт хэрэгт холбогдон шалгагдсан.

Г Ө Г Ү Ү Л Б Э Э Р Э Э Р

325 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн.

+63

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 57.6 хувьтай байна.

+5.4%

Гэмт хэргийн улмаас 845,797,805,525 төгрөгийн хохирол учирсан.

-83.2%

Мөрдөн шалгах ажиллагааны явцад 238,689,979,559 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

-19.0%

Мөрдөн шалгах ажиллагааны явцад 17,137,615,448 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан.

-8.3%

Шүүхээр 192 хэрэг шийдвэрлэгдсэн.

+4

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 1,010 гомдол, мэдээлэл шалгасан.

+35.3%

+2

Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан 39 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.

-1.0%

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт 95.0 хувьтай байна.

+2,124

ХАСХОМ гаргагчийн 49,679 мэдүүлгийг хүлээн авсан.

+24.4%

484 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгасан.

+1,626

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 16,487 этгээдийн ХАСУМ хүлээн авсан.

+1,636

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 16,331 этгээдийн ХАСУМ-ийг хянан шийдвэрлэсэн.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2016–2022)-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАВ


Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх ажлыг 2017-

2022 онд гүйцэтгэсэн. 2023 онд Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэл 75.8 хувьтай гарлаа.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2023–2030) БАТЛАГДАВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Авлигын эсрэг хуулийг үндэслэн Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хугацаатай нийцүүлж, мөн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн саналыг тусган **11** зорилго, **47** зорилт, **207** үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулж, төсөлд үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын дэмжлэгтэйгээр гүйцэтгэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр **2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор** батлагдлаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл бүхий хамтарсан баг эцэслэн боловсруулж, төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөрийн зорилго, зорилтыг танилцуулж, хэрэгжилтийг хангахад анхаарах асуудал, хамтран ажиллах арга замын талаар санал солилцлоо.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтыг сурталчлан таниулах чиглэлээр **3,234** иргэн, төрийн албан хаагчийг хамруулан **14** удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, **3** ном, гарын авлага хэвлүүлж, **2** удаагийн телевизийн нэвтрүүлэг бэлтгэж түгээсэн ба төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн байгууллагатай **20** гаруй удаагийн уулзалт зохион байгууллаа.

Тухайлбал, Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Марк Кейнинг, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшинтэй уулзаж, талууд авлигатай тэмцэхэд иргэний нийгэм, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох судалгааг явуулах зэрэг тодорхой чиглэлээр хамтран ажиллах, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын хооронд харилцан хүндэтгэлтэй хандах зарчимд үндэслэн иж бүрэн, тасралтгүй хамтын ажиллагааг хангах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэж байхаар тохиролцлоо.



ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАМГААЛАВ



2023 оны 06 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсад зохион байгуулагдсан Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 38 дахь удаагийн чуулга уулзалтад оролцож, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын өмнө хүлээсэн Монгол Улсын үүрэг, тус байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг хамгаалав.



АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-наас Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II болон V бүлгийн Монгол Улстай холбогдох хэрэгжилтийн хураангуй тайланг хүлээн авлаа.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үнэлгээний механизмын удирдамжийн 38 дахь хэсэгт *“Гишүүн улс нь улсынхаа үнэлгээний тайланг, эсхүл түүний зарим хэсгийг олон нийтэд нээлттэйгээр нийтлэх бие даасан эрхээ хэрэгжүүлэх нь зүйтэй”* гэж заасантай холбогдуулан Конвенцын хэрэгжилт, хяналт шинжилгээг дэмжих чиглэлээр ажилладаг олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ болох Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын эвсэл (UNCAC Coalition)-ээс дээр дурдсан тайлан болон Конвенцын хэрэгжилтийг тайлагнахтай холбоотой үйл явцыг олон нийтэд ил тод мэдээлэх амлалтад нэгдэх хүсэлтийг ирүүлсний дагуу Монгол Улс тус амлалтад нэгдсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын эвсэлээс гаргасан ил тод байдлын амлалтад нэгдсэний дагуу Конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн тайлан, өөрийн үнэлгээний тайланг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудсанд байршуулав (Үзэх: <https://iaac.mn/post/146795>).

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын төлөөлөл НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран Самао Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн тайланг үнэлж байна.

Конвенцын хэрэгжилтийн хяналтын механизмын I, II үе шат дуусгавар болж байгаатай холбогдуулан НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хяналтын механизмын дараагийн үе шатыг эхлүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, механизмыг боловсронгуй болгох чиглэлээр асуумж ирүүлсний дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлэв.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор байгуулсан Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн анхны хуралдааныг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Хуралдаанаар Дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлах, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн.

Мөн аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газрын төлөөлөл болон сургагч багш нарыг оролцуулан цахим уулзалт хийж, 2023

онд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах чиглэлээр санал солилцож, хамтран ажиллав.

Дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүллээ:

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэгч **77** байгууллагын “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийв. Судалгааны үр дүнд **10** байгууллага мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа, **5** байгууллага

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг ил тод байршуулсан, **14** байгууллага сургалт, сурталчилгаа, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан, **2** байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа, **7** байгууллага Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлж байгаа, **12** байгууллага хэрэгжүүлэх хугацаа болоогүй, **2** байгууллага тодорхой ажил тайлагнаагүй гэж дүгнэгдсэн байна.

- Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг танилцуулах сургалт, уулзалтыг яам, агентлаг, нийслэл, дүүргийн албан тушаалтнуудыг хамруулан 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Уулзалтын үеэр тус журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар хэлэлцэж, заавар, арга зүйн зөвлөгөө өгөв.
- “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-д өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийн санал, танилцуулгыг бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.
- Авлигын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулж хэвших, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газар, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газрын холбогдох албан тушаалтнуудын оролцсон мэдээлэл солилцох уулзалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулав.

Авлигын эсрэг хууль:

18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.2.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;

ЭРСДЭЛД СУУРИЛСАН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, мөн эрсдэлийн түвшнээс хамааран урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг ялгамжтай төлөвлөж хэрэгжүүлэх хүрээнд:

- Боловсролын зээлийн сан, Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн захиран зарцуулалтын байдал, Сангийн яамны олонулсынзээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ил тод байдал, эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, “Улаанбаатар смарт карт” ХХК-аас гаргасан цахим карт “U money”-ийн ашиглалт, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, “Монгол шуудан” ХК, “Төрийн орон сууцны корпорац” ТӨҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, Татварын маргаан таслах комиссын үйл ажиллагаатай тус тус танилцаж, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэв.
- Гаалийн ерөнхий газар, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Онцгой байдлын ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар зэрэг Засгийн газрын **10** агентлаг, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн боловсролын газар зэрэг нутгийн захиргааны **4** байгууллага, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, түүний харьяа “Эрдэнэт медиал” эмнэлэг, “Барилгын хөгжлийн төв”, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК, “Монгол шуудан” ХК, “И-Монгол академи” УТҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь салбар зэрэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой **9** хуулийн этгээд, нийслэлийн **6** дүүргийн ерөнхий боловсролын **18** сургууль зэрэг нийт **44** байгууллагад ажиллалаа.

Авлигын эсрэг хууль:

18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.6.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигад өртөх эрсдэлийг бууруулах, авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг бууруулах, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, дотоод хяналтын механизмыг сайжруулах, ил тод байдлыг хангах, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар **38** байгууллага, албан тушаалтанд нийт **193** асуудал бүхий **45** зөвлөмж хүргүүлэв.

Д/д	Байгууллага, албан тушаалтны нэр	Зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн заалтын тоо
1.	Монгол Улсын Ерөнхий сайд	2	10
2.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдад	3	11
3.	Боловсрол, шинжлэх ухааны сайд	3	27
4.	Эрүүл мэндийн сайд	1	4
5.	Зам, тээврийн сайд	2	5
6.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, хувийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	1	1
7.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	4
8.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	1	8
9.	Эрүүл мэндийн яам	1	10
10.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	1	1
11.	Онцгой байдлын ерөнхий газар	1	4
12.	Татварын ерөнхий газар	1	8
13.	Гаалийн ерөнхий газар	1	6

14.	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба	2	4
15.	Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шийдвэрлэх газар	1	1
16.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	1	5
17.	Нийслэлийн эрүүл мэндийн газар	1	4
18.	Боловсролын ерөнхий газар	1	3
19.	Хавдар судлалын үндэсний төв	1	4
20.	Налайх дүүргийн ИТХ-ын дарга	1	4
21.	Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга	1	4
22.	Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, хувийг тус аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт	1	4
23.	Цэргийн төв эмнэлэг	1	5
24.	Төв аймгийн Засаг дарга	1	5
25.	Аймгийн Засаг дарга нарт	1	6
26.	Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс	1	2
27.	Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын дарга, хувийг тус дүүргийн Засаг даргад	1	1
28.	Багахангай дүүргийн ЗДТГ	1	1
29.	Сүхбаатар аймгийн Засаг дарга, хувийг ИТХ-ын дарга	1	3
30.	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	1	6
31.	Баянзүрх дүүргийн Засаг дарга	1	4
32.	Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар	1	2
33.	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	1	3
34.	“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ	1	4
35.	“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК	1	3
36.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1	7
37.	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК	1	6
38.	Хөвсгөл аймгийн Их-Уул сумын “Их-Уул дулаан” ХК	1	3
Нийт		45	193

Төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 2022 оны **15**, 2023 оны **10** зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт дунджаар **67.0** хувьтай байна.



УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Төрийн үйл ажиллагаанд авлига гарах нөхцөлийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх, үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг сайжруулах, цахим үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэв. Тухайлбал,

- Ричард Холловэйн “Төрийн бус байгууллага авлигатай тэмцэх нь” гарын авлагыг танилцуулах сургалт-хэлэлцүүлгийг “ТББ-ын нөлөөллийн арга хэмжээ”, “ТББ-ын хяналт шинжилгээ”, “ТББ-ын авлигатай тэмцэх бусад үйл ажиллагаа” сэдвээр зохион байгууллаа. Сургалт-хэлэлцүүлэгт **18** төрийн бус байгууллагын төлөөлөл хамрагдав.



- Авто замын салбарт авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, таслан зогсоох, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид түргэн шуурхай, ил тод, аюулгүй хүргэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, цаашид шийдвэрлэх арга замын талаар **“Явган замын хавтан, авто замын хашлагийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт”** сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн ЗДТГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн авто замын газар, нийслэлийн **6** дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн төлөөлөл оролцов. Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг тусгасан зөвлөмжийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.




- Боловсролын салбарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон хууль бус хандив, тусламж, анги засвартай холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн үр дүн, тулгамдаж буй асуудал, цаашид



авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор **“Боловсролын салбар дахь тулгамдсан асуудал”** сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт боловсрол, төсөв, эрүүл мэнд, барилга, стандартын салбарын мэргэжилтнүүд оролцсон ба хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлтэд үндэслэн Зөвлөмж хүргүүлэв.



- “Улсын хилээр төрийн хяналтын доор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам”-ыг хэрэгжүүлэгч байгууллагууд болон импорт, экспортын бараанд тусгай зөвшөөрөл олгодог байгууллагуудын үйл ажиллагаанд хүнд суртал, чирэгдэл үүсгэх, ашиг сонирхлын зөрчил бий болох эрсдэлээс сэргийлэх, уялдаа холбоог хангах, цахимаар мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Гаалийн ерөнхий газартай хамтран **“Экспорт, импортын зөвшөөрөл олгох, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын мэдээллийг цахимжуулах гарц, шийдэл”** сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг төрийн байгууллагын **20**, импортлогч, экспортлогч аж ахуйн нэгжийн **20**, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын нэгж, гаалийн газар, хороодын гаалийн улсын **50** байцаагч танхимаар болон цахимаар оролцов.

- Хүний эрхийн үндэсний комисстой хамтран **“Цэргийн анги дахь ашиг сонирхол ба хүний эрхийн зөрчил”** сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Хүний эрхийн үндэсний комисс, Батлан хамгаалах яамны эрх бүхий албан тушаалтнууд, цэргийн анги, нэгтгэлийн **15** албан хаагч оролцож, “Батлан хамгаалах салбар дахь авлигын ерөнхий нөхцөл байдал, анхаарах асуудал”, “Цэргийн албан хаагчийн эрхийн хэрэгжилтийн байдал”, “Батлан хамгаалах салбар дахь авлигын эсрэг үйл ажиллагаа ба хүний эрхийг хэрэгжүүлэх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн



үеэр тус яамны хуулиар нууцалсан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, хугацаат цэргийн албан хаагчаар албадан хөдөлмөр эрхлүүлэх, албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах зэрэг үйлдлийг таслан зогсоох, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар санал солилцож, цаашид хамтран ажиллахаар боллоо.

- “Монголын Барилгын инженерүүдийн холбоо” ТББ-тай хамтран “**Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй**” 2 дахь шатны хэлэлцүүлгийг “Барилгын салбарын ил тод байдал: Авлигаас урьдчилан сэргийлэх нь, олон улсын туршлага” сэдвийн хүрээнд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Солонгосын Барилгын инженерүүдийн холбоо (KSCE), Тайванийн Барилгын инженерүүдийн холбоо (CICNE)-ны төлөөллөөс гадна Бүгд Найрамдах Солонгос Улсын Аудит, хяналтын зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн, профессор И Юн Так болон Барилга, хот байгуулалтын яамны эрх бүхий албан тушаалтнууд, “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-ын төлөөлөл “Салбарын авлигын эрсдэлийг үнэлэх олон улсын аргачлал: Монгол Улсын онцлог”, “Монголын барилгын салбарт тулгарч буй хүндрэл бэрхшээл, Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Барилгын салбарын ил тод байдал”, “БНСУ-ын олон улсын төслүүдэд техникийн аудит хийх аргачлалын судалгаа, жишээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт **55** хүн оролцож барилгын салбарыг авлигаас ангид байлгахын тулд тогтолцоог сайжруулж, өөрчлөх арга замыг тодорхойлох чиглэлээр санал солилцлоо.

МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЭЛ, ШААРДЛАГЫН МӨРӨӨР АЖИЛЛАВ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн өмнөх оны **37**, 2023 оны **97**, нийт **134** мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр ажиллан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх, гэмт хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтанд нийт **3** зөвлөмж, **11** албан бичиг хүргүүлэв.

Төрийн байгууллага, албан тушаалтанд хуулийн хэрэгжилт хангуулах, зөрчил арилгуулах, хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн **54** албан бичгийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавив.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль:

29.6 дугаар зүйл. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ

1. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана.

2. Хуулийн этгээд нь мөрдөгч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай мөрдөгч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй.

ТУШААЛ, ШИЙДВЭР, ЖУРАМ, ДҮРЭМ ХЯНАВ

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны “Заавар батлах тухай” А/183 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын дагуу **63** тушаал, шийдвэр, дүрэм, журам хянаснаас **44** нь хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй байсан тул эдгээр дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай шаардлагыг хүргүүлж, үүний дагуу **19** шийдвэр хүчингүй болж, **2** шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авсан тухай хариу ирүүлээд байна.

Авлигын эсрэг хууль:

18.4. Авлигатай тэмцэх газар дараахь бүрэн эрхтэй:
18.4.2. авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ ХЯНАВ

Баян-Өлгий, Ховд, Увс аймаг болон Налайх дүүргийн ИТХ, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Биокомбинат” ТӨХК, Дархан-Уул аймгийн “Дархан-Ус суваг” ХХК-аас ирүүлсэн ёс зүйн **12** дүрмийн төслийг хянаж, холбогдох саналыг тусгуулахаар хүргүүлэв.

Авлигын эсрэг хууль:

6.1. Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:
6.1.9. төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ДЭХ ОРОЛЦОО

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалтын зохицуулалттай холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт байнгын төлөөлөл орж ажилласан бөгөөд Улсын Их Хурал хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан.

“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Авлигатай тэмцэх газрын албан хаагчид дараах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна:

- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл боловсруулах;
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах;
- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах;
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах;
- Монгол Улс Цахим гэмт хэргийн тухай Будапештын конвенцод нэгдэн орох

- шаардлагатай эсэх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг;
- Улсын Их Хурлаас гүйцэтгэх ажилд тавих хяналтын тухай хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсэг;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл боловсруулах;
- Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны үзэл баримтлал, асуулга, асуулгыг нөхөх зааврыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төрийн байгууллага Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйл (Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа)-ийн **5.1** болон 6 дугаар зүйл (Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа)-ийн **6.1**-д заасан нийтлэг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилгоор Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна:

- тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага өөрийн байгууллага, албан хаагчдын хүрээнд болон олон нийтэд зориулсан авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах;
- тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага өөрийн байгууллага, албан хаагчдын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах.

Авлигатай тэмцэх газар нь улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлын хүрээнд төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, дэмжлэг үзүүлэн ажиллав.



2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн дундаж хувь:

УИХ-ын харьяа байгууллага	55%
Яам	55%
Агентлаг	58%
Аймаг, нийслэл	63.7%
Дүүрэг	58%

2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийтлэг байдлаар тусган хэрэгжүүлбэл зохих **5** зорилт, **14** арга хэмжээг санал болгож, нэмэлтээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг цахим санд байршуулах талаар видео хичээл боловсруулан хүргүүлэв.

ЦАХИМ СИСТЕМИЙН ИНТЕГРАЦИЛАЛ



**УХААЛАГ
ЗАСАГ**


Авлигатай тэмцэх газрын ашиглаж буй meduuleg.iaac.mn, iad.iaac.mn, e-office, smart.iaac.mn, search.iaac.mn, хасхот.iaac.mn цахим системийг интеграцчилах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, системийн найдвартай үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах ажлыг Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Ухаалаг засаг” төслийн хүрээнд 2021 оны 12 дугаар сараас эхлүүлсэн бөгөөд системийг 2 үе шаттай хөгжүүлэхээр ажиллаж байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Гадаад улс орноос Монгол Улсад суугаа Элчин сайд нарыг хүлээн авч уулзан, авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээг танилцуулан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Тухайлбал,

- 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мохиндер Пратап Сингхийг хүлээн авч уулзав;
- 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ноён Цай Вэньруйг хүлээн авч уулзан, тус улсын ижил чиг үүрэг бүхий холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан туршлага судлах чиглэлд хамтран ажиллах талаар санал солилцов.
- 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ноён Кобаяаши Хироюкиг хүлээн авч уулзан, авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, ололт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулав.
- 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ноён Зафер Атешийг хүлээн авч уулзав.



- 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хатагтай Шэнь Миньжуанийг хүлээн авч уулзан Монгол Улсын авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, ололт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээ, туршлага, үр дүн, ижил төстэй чиг үүрэг бүхий холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хууль ёсны хөрөнгө оруулалт, шударга бизнесийн орчныг хамгаалах чиглэлээр харилцан туршлага судлах, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй зарим хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа авах чиглэлд анхаарч ажиллах талаар санал солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар харилцан тохирлоо.



Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл байдлыг судлан шинжлэх, шударга, ил тод, хариуцлагатай тогтолцоог бий болгох, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зэрэг чиглэлд гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн дараах уулзалт, яриа хэлэлцээрийг зохион байгууллаа:

- 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Тогтолцооны шударга, ил тод байдлыг хангах нь” төслийг хамтран хэрэгжүүлж буй Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын суурин төлөөлөгч Стивен Кенттэй уулзалт хийж төслийн хэрэгжилтийн талаар санал солилцов.



- 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын Иргэний аюулгүй байдал, ардчилал, хүний эрхийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн даргын орлогч, хатагтай Узра Зэяаг хүлээн авч уулзав. Уулзалтад АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ноён Ричард Буанган, Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн дарга, ноён Кэлли Базби, Төрийн нарийн бичгийн даргын орлогчийн туслах, хатагтай Мэйт Хостэттэр тэргүүтэй албаны хүмүүс оролцов.




- 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн зохицуулагч Игли Хасанитай уулзалт хийж, авлигатай тэмцэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлогын талаар дэлгэрэнгүй танилцуулж, талууд цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө, орлогын мэдүүлэг хянан шалгах болон авлигын гэмт хэрэг мөрдөн шалгах чиг үүрэгтэй албан хаагчдыг сургах, чадавхыг сайжруулах, гадаад улсаас хөрөнгө буцаах чиглэлд харилцан туршлага солилцож, хамтран ажиллахаар тохиролцов. Уулзалтаар харилцан тохиролцсоны дагуу Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засаг, орчны асуудал хариуцсан зөвлөх Гурбан Бабаев, Лорензо Риласциати, Максим Мишалов Драгуновтай авлигатай тэмцэх үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах санал солилцох цахим уулзалтыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хийж, хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр ярилцав.



- 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Австрали Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин Сайдын яамны Австралийн Холбооны цагдаагийн газрын төлөөлөгч ахлах ажилтан Роб Харрисон болон Гадаад харилцааны ажилтан Жефф Коклес нартай уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцон хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд тодорхой арга хэмжээ зохион байгуулахаар ярилцав.

- 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүс нутгийн Авлигатай тэмцэх хэлтсийн зөвлөх Хатагтай Анника Витес, Хилийн удирдлагын зохицуулагч Хатагтай Валентина Панциери, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн шинжээч Ноён Лорензо Пиациентини нарыг хүлээн авч уулзав.




- 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын урилгаар авлигатай тэмцэх асуудлаар зөвлөгөө өгөхөөр манай улсад ирсэн "Транспэрэнси интернэшнл" олон улсын байгууллагын үүсгэн байгуулагч, доктор Петер Айгентай уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцов.



- 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сайн туршлагыг солилцох, авлигатай тэмцэх байгууллагын цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хамтран ажиллахаар “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав.
- 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээ (ACN)-ний Ерөнхий зохицуулагч Хатагтай Олга Савран тэргүүтэй төлөөлөгчидтэй цахим уулзалт хийж, 2023, 2024 оны Монгол Улсын оролцоо, 2024 онд гүйцэтгэх Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тавдугаар мониторингийн тухай зэрэг асуудлаар ярилцав.
- 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Олон улсын валютын сангийн ажлын баг Монгол Улсад ажилласантай холбогдуулан Монгол Улс дахь суурин төлөөлөгч Ноён Сеок Хюн Юн, Хуулийн хэлтсийн ахлах зөвлөх Хатагтай Тина Буржайлиани нарыг хүлээн авч уулзан, Монгол Улс дахь авлигын ерөнхий нөхцөл байдал, 2022-2023 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны мэдээлэл, шаардлагатай бусад асуудлаар тодруулга өгөв.
- 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсад хэрэгжүүлж буй “Хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр (2021-2027)”-ийн хүрээнд хууль зүйн салбарт 2024 оноос 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх шинэчлэлийн шинэ хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан Европын холбооны төлөөлөгчидтэй зөвлөлдөх уулзалт хийж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулан, санал солилцов.
- 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Дэлхийн банкны Шударга байдлын дэд ерөнхийлөгчийн газрын Бүс нутгийн менежер Ноён Ришелию Ломакс, Самуэл Бвана нарыг Авлигатай тэмцэх газрын дэд дарга хүлээн авч уулзав.
- 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр АНУ-ын Маршалын албаны Олон Улсын мөрдөн шалгах ажиллагааны хэлтсийн дэд маршал Карлос Гриффит, Олон Улсын гүйцэтгэх ажлын хэлтсийн ахлах мөрдөгч Алфред Целес, АНУ-ын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын атташе Жоел Ортез нарыг хүлээн авч уулзан, авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны үед гадаад улс руу оргон зайлсан этгээдийг буцаан авч ирэх чиглэлд хамтран ажиллах талаар санал солилцов.



- 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хууль зүйн сайд Хө Рунг, Нийгмийг аюулаас хамгаалахын сайд Ван Сяохун нартай Бээжин хотноо уулзалт хийж, холбогдох асуудлаар хамтран ажиллахаар зөвшилцөв.
- 2023 оны 10 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Жилийн бүгд хуралд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид оролцож 2024 онд Монгол Улсад хийгдэх мониторингийн төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр уулзалт хийв.
- 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас Монгол Улсын хууль сахиулах салбарын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд урт хугацааны төсөл хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан тус албаны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх шинжээч Ноён Лоренцо Пиацентини болон албаны хүмүүстэй уулзаж, санал солилцов.
- 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр НҮБ-ын Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан Тусгай илтгэгч Хатагтай Маргарет Саттертуэйг хүлээн авч уулзан байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, санал солилцов.
- 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр АНУ-ын Хууль зүйн яамны Олон улсын Прокурорын хөгжлийн туслалцаа, сургалтын албаны Ази, Номхон далайн бүс нутгийн захирал Еи Тин Воо тэргүүтэй Холбооны мөрдөх товчоо, Мансууруулах бодис, хууль сахиулах асуудал хариуцсан товчооны төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.
- 2023 оны 12 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд АНУ-ын Атланта хотноо зохион байгуулагдсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын Оролцогч талуудын дээд хэмжээний 10 дугаар чуулганд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид оролцож байр сууриа илэрхийлэн, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хянан шалгах хорооны удирдлагын төлөөлөгчидтэй хоёр талт уулзалт хийж, эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд хамтран ажиллах, мэдээлэл шуурхай солилцох арга хэмжээ авахаар ярилцав.
- Малайз Улсын Авлигын эсрэг хорооны Ерөнхийлөгч Дато Мохд Хафез Бин Назартай уулзаж, 2024 оны эхний хагаст Малайз Улсад зочлон, хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулахаар харилцан тохирлоо.



АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЖ, ГАДААД УЛС ОРНЫ ТУРШЛАГААС СУРАЛЦАВ

Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад өргөнөөр хамруулах бодлого баримтлан ажиллалаа. 2023 онд дараах сургалтад албан хаагчдыг биечлэн болон цахимаар суралцуулав. Үүнд:



2023 оны 01 дүгээр сарын 09-13-ны өдөр, 2023 оны 03 дугаар сарын 17-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хорооноос зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн тусгайлсан сургалтад **31** албан хаагч;

- Авлигын эсрэг олон улсын байгууллага хоорондын холбооноос зохион байгуулсан “Авлигын хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах санхүүгийн шинжлэх ухаан” сэдэвт цахим сургалтад **6** албан хаагч;
- 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга (StAR)” хөтөлбөрийн хүрээнд “Үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийн этгээд, эрх зүйн бусад бүтцүүдийг хянан шинжлэх нь” (Эцсийн өмчлөгчийг тодорхойлох) сэдэвт вебинарт **30** албан хаагч;
- 2023 оны 04 дүгээр сарын 17-28-ны өдрүүдэд АНУ-ын Элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Цахим гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтад **2** албан хаагч;
- 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 07-ны

өдрүүдэд АНУ-ын Хууль сахиулах олон улсын академиас Тайланд Улсад зохион байгуулсан “Хөрөнгө буцаах ажиллагаа ба мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтад **2** албан хаагч;

- 2023 оны 05 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд АНУ-ын Төрийн департаментын Аюулыг бууруулах хамтын ажиллагааны алба, Номхон далайн баруун хойд эргийн үндэсний лаборатори (PNNL) болон Дэлхийн гаалийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх, хориг арга хэмжээнээс зайлсхийхийн эсрэг болон мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтад **3** албан хаагч;



2023 оны 05 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга”-тай хамтран тус санаачилгын зөвлөх багш, санхүүгийн салбарын ахлах шинжээч Найжел Бартлетт, Лиза Боствик, Жонатон Бентон, Фредерик Раффрэй нарын удирдан зохион байгуулсан “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалт”-ыг Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Дотоод хэргийн их сургууль болон Авлигатай тэмцэх газрын нийт **26** албан хаагчийг хамруулан Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулав. 2023 оны 05 дугаар сарын 31, 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Авлигатай тэмцэх хууль сахиулах байгууллагын дэлхийн сүлжээнээс зохион байгуулсан “Криптовалют”, “Кэйс судлал” сэдэвт цахим сургалтад **5** албан хаагч;

- 2023 оны 05 дугаар сарын 31-нээс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний бүс нутгийн хууль сахиулах албан хаагчдын сургалтад **2** албан хаагч;
- 2023 оны 08 дугаар сарын 31, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Авлигын эсрэг олон улсын академи (IACA) болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан авлигыг зөв хэмжих, авлигыг хэмжих өгөгдлүүдийг ашиглах талаарх олон улсын цахим сургалтад **6** албан хаагч;
- 2023 оны 09 дүгээр сарын 28, 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын Дэлхийн нийтийн сүлжээ (GlobE)-нээс зохион байгуулсан “Интернет мөрдлөг ба нээлттэй эх сурвалж” сэдэвт хоёр үе шат бүхий цахим сургалтад **15** албан хаагч;
- 2023 оны 10 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хорооноос зохион байгуулсан “Томоохон төсөл хөтөлбөрт авлигатай тэмцэх ажиллагаа” сэдэвт олон улсын сургалтад **2** албан хаагч;



2023 оны 10 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд Олон улсын валютын сангийн Кавказ, Төв Ази, Монгол Улсын бүс нутгийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы хотноо зохион байгуулсан “Авлигатай тэмцэх нь: Эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, стратегийн чиг хандлага” сэдэвт сургалтад **2** албан хаагч;

- АНУ-ын Номхон далайн командлалын дэргэдэх Ази-Номхон далайн аюулгүй байдлын судалгааны төвөөс 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулсан Аюулгүй байдлын цогц хамтын ажиллагааны олон улсын сургалтад **1** албан хаагч суралцаж төгссөн.

Олон улсын хурал, зөвлөгөөн, чуулганд оролцож, авлигатай тэмцэх чиглэлээр олон улс, бус нутаг, тодорхой улс орнуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, олон улсын болон улс хоорондын хамтын ажиллагаа, сайн туршлагатай танилцахын зэрэгцээ гадаад улсаас хөрөнгө буцаасан Монгол Улсын туршлагын талаар танилцуулж, илтгэл хэлэлцүүлэн, холбогдох талуудтай олон талт болон хоёр талт уулзалтууд зохион байгууллаа. Тухайлбал,

- 2023 оны 02 дугаар сард зохион байгуулагдсан Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын гэмт хэрэг мөрдөн шалгах олон улсын сургууль болон Итали Улсын Санхүү, эдийн засгийн яамны харьяа хууль сахиулах байгууллагаас зохион байгуулсан Хөрөнгө буцаах талаарх чуулган;



- 2023 оны 03 дугаар сард НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Абу Дабигийн тунхаг хөтөлбөр”-ийн хүрээнд Тайланд Улсад зохион байгуулагдсан олон улсын семинар;
- 2023 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Филиппин Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн Авлигын эсрэг санаачилгын 11 дүгээр Бүс нутгийн чуулган;
- 2023 оны 05 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулсан НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас зохион байгуулсан “Торгоны зам” эдийн засгийн бүсийн авлигын эсрэг мэргэжилтнүүдийн сүлжээний 3 дахь удаагийн хурал;
- 2023 оны 06 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Дэлхийн банкнаас АНУ-д зохион байгуулсан Хөгжлийн төлөөх Авлигатай тэмцэх ажиллагааны дэлхийн форум;
- 2023 оны 07 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Австри Улсад зохион байгуулагдсан Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын Дэлхий нийтийн сүлжээ (GlobE)-ний 4 дүгээр чуулган;
- 2023 оны 07 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний Истанбулын арга хэмжээний төлөвлөгөөний тавдугаар мониторингийн бэлтгэл ажлын хүрээнд Төв Ази болон Монгол Улсад зориулан Франц Улсад зохион байгуулагдсан сургалт-арга хэмжээ;
- 2023 оны 09 дүгээр сард Бүгд Найрамдах Казахстан Улсад зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Хууль сахиулагчдын 13 дугаар уулзалт;
- 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээнээс зохион байгуулсан “Бизнесийн шударга байдлын бүлэг”-ийн цахим хурал;
- 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо зохион байгуулагдсан Интерполын Ерөнхий Ассамблейн 91 дүгээр чуулган;
- 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын Дэлхий нийтийн сүлжээний 13 дугаар Ерөнхий чуулган.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023

- 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохион байгуулагдсан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засаг, байгаль орчны хэмжигдэхүүний асуудлаарх форум;
- 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Австри Улсын Вена хотод зохион байгуулсан “Сайн засаглалыг дэмжих замаар бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах нь: байгаль орчин, авлига, мөнгө угаах гэмт хэрэг хоорондын уялдаа холбоо” сэдэвт хурал;
- 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Тайланд Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Жилийн бүгд хурал.



ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ҮЙЛ АЖИЛЛАГАА



- АНУ-ын Төрийн департаментын дэргэдэх Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах асуудал эрхэлсэн газрын санхүүжилтээр “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” (2021-2024) төслийг хэрэгжүүлж байгаа Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын суурин төлөөлөгчтэй Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал тэргүүтэй албан тушаалтнууд уулзаж, төслийн хэрэгжилтийн талаар ярилцав. Төслийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд Сингапур Улсын хууль сахиулах, яллах, шүүн таслах чиг үүрэг бүхий байгууллагатай уулзаж, туршлага судлан, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр болов.
- 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал тэргүүтэй төлөөлөгчид Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг 2” төслийн Ажлын хэсгийн ахлагч Сиу Чью Күек, дэд ахлагч Женнифер Гуй, ахлах зөвлөх Себастиан Фуу нартай уулзалт хийж, төслийн явцын талаар мэдээлэл өгч, цаашид төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахаар тохирлоо.



- 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй албан тушаалтнууд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч хатагтай Илэйн Конкиевичтэй хийсэн уулзалтаар цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцон, авлигатай тэмцэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр тохирсны дагуу холбогдох төслийн саналыг, мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-ын санхүүжилтээр хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 2025-2028 онд хэрэгжүүлэх төслийн саналыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлээд байна.

МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагууд, яамд, Засгийн газрын агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

- Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан **"Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал"**-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээллийг хүргүүлэв.

Авлигын эсрэг хууль:

26.1.Улсын Их Хурал авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр мэдээлнэ.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд:

- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан Авлигатай тэмцэх газрын мэдүүлэг гаргавал зохих албан хаагчдын 2022 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүртгэлийн тухай мэдээллийг хүргүүлэв.

Авлигын эсрэг хууль:

11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн “Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар” болон мөрдөн шалгах ажиллагаа явуулсан авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх тойм мэдээг хүргүүлэв.

Үндэсний статистикийн хороонд:

- ХАСХОМ-ийн тайлан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг хүргүүлэв.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдэж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийн дүнгээр төрийн байгууллагуудыг тэргүүлэн 99.9 хувь буюу “Сайн” үнэлгээ авлаа.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай холбоотой гомдол, мэдээллийг дараах сувгаар хүлээн авч байна:

- Биечлэн (Авлигатай тэмцэх газрын байранд)
- Шуудангаар (Авлигатай тэмцэх газар, 5-р хороолол, Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот 14250)
- Цахим хуудсаар (www.iaac.mn)
- Цахим шуудангаар (contact@iaac.mn)
- Цахим үйлчилгээний нэгдсэн порталаар (e-mongolia.mn)
- 110 тусгай дугаараар (төлбөргүй)

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

24.1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

24.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам:

7. Авлигатай тэмцэх газар
- Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгдөг төрийн албан тушаалтны үйлдсэн авлигын гэмт хэргийн тухай
 - Авлигын гэмт хэргийн илрүүлэлтийн тухай мэдээ
 - Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явцын тухай

2023 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 3,749 гомдол, мэдээлэл хүлээн авсан. Үүнээс:

- Мөрдөн шалгах хэлтэст **2,015** буюу **53.7** хувь
- Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст **980** буюу **26.1** хувь
- Гүйцэтгэх ажлын хэлтэст **430** буюу **11.5** хувь
- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст **242** буюу **6.4** хувь
- Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд **81** буюу **2.2** хувь
- Тамгын хэлтэст **1** буюу **0.02** хувь нь тус тус хуваарилагдан хянан шалгагдсан байна.



Гомдол, мэдээллийн тоо, оноор

Авлигатай тэмцэх газраас байгууллагын өргөдөл, гомдлын менежментийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь” төслийн нэгдүгээр шатны ажлыг “Хөгжлийн эрх зүйн төв” ТББ-тай хамтран гүйцэтгэлээ. Монгол Улсад авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, хариу мэдэгдэх процессыг зураглаж, өнөөгийн нөхцөл байдлыг Бүгд Найрамдах Солонгос Улсын “Clean Portal” системтэй харьцуулан шинжилгээ хийж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлон цаашид боловсронгуй болгох санал, зөвлөмж өгсөн.

Авлигатай тэмцэх газарт иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг тодорхойлох судалгааг хийж, дээр дурдсан судалгааны үр дүнтэй нэгтгэснээр цаашид тусгай дугаарын утсаар дуудлага хүлээн авах программ нэвтрүүлэх, өргөдөл, гомдол, мэдээллийг бүртгэх “Smart office” программыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.




СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



"...НЭГДЬЕ" СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЯН

Иргэдэд авлигыг үл тэвчих хандлага төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэхийг уриалах, авлигатай тэмцэх үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Үгүй гэж хэлээд өөрчилье" уриатай авлигын эсрэг "...Нэгдье" соён гэгээрүүлэх аяныг улсын хэмжээнд нэг сарын хугацаатай зохион байгууллаа. Аянд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд нэгдэж, хамтран ажиллав.

"НЭГДЬЕ" нөлөөллийн аяны хүрээнд **22** төрлийн видео, **20** ширхэг постерыг олон нийтэд түгээж, нийгмийн сүлжээн дэх хандалт **3,259,800** / давхардсан тоогоор/ хүрсэн байна.



“ШУДАРГА ЁСНЫ КЛУБ”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 1, 12, 24, 32, 40, 84 дүгээр сургууль болон Хэнтий аймгийн ерөнхий боловсролын 11 сургуульд байгуулсан “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал, зөвлөгөө, мэдээлэл өгөв.

2023 онд Монгол Улсын их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд “Шударга ёсны клуб” нээв.

“Сэтгэл судлалын үндэсний төв” ТББ-тай хамтран “Шударга ёсны клуб” ажиллуулж буй сургуулиудын эцэг, эх, зохион байгуулагч багш нийт **110** хүнд “Шударга ёсны боловсрол: Эцэг эхчүүдийн оролцоо” чөлөөт уулзалт, ярилцлага зохион байгуулж, хүүхэд шударга, зөв хүн болж төлөвшихөд эцэг эхийн оролцоо, үүрэг ямар байх, хүүхдэд шударга ёсыг хэрхэн төлөвшүүлэх талаар хэлэлцэв.



АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүргийн хүрээнд нийт **334** удаагийн сургалтыг **233** байгууллагын **35,573** хүнийг хамруулан зохион байгуулснаас төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд **204** удаагийн сургалтаар **31,005**, хувийн хэвшлийн байгууллагад **18** удаагийн сургалтаар **1,079**, иргэд, олон нийтэд зориулсан **7** удаагийн сургалтаар **2,828**, оюутан залууст зориулсан **4** удаагийн сургалтаар **661** хүнийг авлигын эсрэг сургалтад хамруулсан байна.

СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭВ



- Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш бэлтгэх, тэднийг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр ханган дэмжлэг үзүүлэх ажлыг 2019 оноос үе шаттайгаар зохион байгуулж байна. 2023 онд эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгаалал, батлан хамгаалахын салбарын болон төрийн өмчит компанийн **90** албан хаагчийг сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад хамруулж, гэрчилгээ олгов.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, түүний харьяа төрийн өмчит компаниудын шинээр бэлтгэгдсэн сургагч багш нартай хамтран “Бид ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” сэдэвт сургалт, сурталчилгааны 1 сарын аян зохион байгуулав.

Авлигын эсрэг хууль:

18.1. Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.5. авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ШУДАРГА ЁСНЫ ҮЗЭЛ, ХАНДЛАГА БИЙ БОЛГОХ АГУУЛГА ТУСГАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн агуулгыг тусгах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал,

- Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн ёс зүйн сэдвийг тусгах, заавал судлах хичээлийн жагсаалтад оруулах талаар судлан шийдвэрлэх, сургалтын хөтөлбөрт тогтмол хугацаанд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж үр дүнг тооцож байх, багш нарыг сургагч багшаар бэлтгэх агуулга бүхий зөвлөмжийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайдад хүргүүлсэн. Уг зөвлөмжийн хэрэгжилтийг

хянахад төрийн өмчийн **17**, хувийн хэвшлийн **1** их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн ёс зүйн агуулгыг тусгасан байв. 2024 онд дээр дурдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах болон Дэлхийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хэрэгжүүлж буй богино хугацааны сургалтын төвийн сургалтын агуулга, хөтөлбөрт дурдсан сэдвийг тусгуулахаар төлөвлөж байна.



- Боловсролын ерөнхий хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгах агуулга, үзэл баримтлалын талаар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн төлөөлөгчидтэй, “Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”, “Ерөнхий боловсролын математик, монгол хэл, нийгэм судлал, судлагдахууны сургалтын хөтөлбөрт ёс зүй, ёс суртахуун, шударга байдлын агуулгыг тусгах, туршилтын удирдамж”-ийн талаар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрх бүхий албан тушаалтнуудтай хэлэлцүүлэг хийж, туршилтын хичээлийг зохион байгуулах хүрээг тодорхойлон, 2023-2024 оны хичээлийн жилийн III улирлаас ерөнхий боловсролын **25** сургуулийн 11 дүгээр ангид заахаар хамтран ажиллаж байна.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ

- “Монголын шүүгчдийн холбоо” ТББ-тай хамтран шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулга бүхий **7** төрлийн постер бэлтгэж, **7000** ширхэг хэвлэж, олон нийтэд түгээв.

- “Бодлогод залуусын хяналт” ТББ, Сонгуулийн ерөнхий хороо, Нээлттэй нийгэм форум, “Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ, Тунгаахуй өгөгдлийн урлантай хамтран “Дата эрх чөлөө” үзэсгэлэнг “Сонгуулийн хяналт” сэдвийн дор зохион байгуулахад туслалцаа үзүүлж хамтран ажиллав. Үзэсгэлэнгийн үеэр УИХ-ын 2020 оны, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд өрсөлдсөн нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын анхдагч тайлан, 2020-2024 оны УИХ-ын гишүүдийн ирцийн мэдээлэл, ашиг сонирхлын зөрчилтэй хууль баталж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээний талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулсан.

Авлигын эсрэг хууль:

18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023

- “Монголын хөл бөмбөгийн холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд сурталчилгааны материалыг байршуулах, үе үеийн тамирчдын оролцсон авлигын эсрэг аяны уриалга бүхий шторк хийж, олон нийтэд түгээн сурталчлав.
- “Авто замчдын холбоо”, “Монголын барилгын инженерүүдийн холбоо”, “Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг”, “Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо”, “Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо”, “Монголын улаан загалмай нийгэмлэг”, “Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа”, “Залуус эрүүл мэнд төв”, “Төгс бүсгүйчүүд” зэрэг төрийн бус байгууллагын төлөөллийг сургалтад хамруулж, авлигын эсрэг сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.



АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ КОНТЕНТ

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор **56** контент, видео шторк бүтээж, гудамж талбай, үйлчилгээний газар, олон нийтийн газарт байршуулав.

Авлигын эсрэг контентыг “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулсан ба давхардсан тоогоор **2,481,685** хүнд хүрч, дагагчдын тоо 2022 онд **66,497** байсан бол 2023 онд **72,631** болж, **9.2** хувиар нэмэгдсэн байна.



Авлигын эсрэг хууль:

18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.5.авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;



“ТОВШ” АППЛИКЭЙШН



Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу “И-Монгол академи” УТҮГ-тай хамтран хүнд суртал, албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэх, төрийн үйлчилгээнд мониторинг хийх зорилготой “Тоншуул” аппликэйшнийг “Товш” болгон өөрчилж, хөгжүүлэн иргэд, олон нийтээс мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүллээ. Аппликэйшны дизайныг “И-Монгол академи” УТҮГ-ын багтай хамтран гүйцэтгэж, Playstore, Appstore-т байршуулсан бөгөөд аппликэйшний мэдээллийн санд **1,943** төрийн байгууллага бүртгэгдээд байна.

СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ ТҮГЭЭВ

“...Нэгдье” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Шударга тоглоё” буддаг ном 1,000, “Авлигатай тэмцэх газар хэрхэн гомдол гаргах вэ?” брошюр 5,000 ш, “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?” брошюр 5,000 ш, авлигын хор хөнөөлийг ухуулан тайлбарласан 2 төрлийн постер 12,000 ш, “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” гарын авлага 1,000 ш, номын хавчуурга 3000 ш, цэвэр усны шошго 1,000 ш, хаалганы стикер 9,000 ш, бугуйвч 5,000, фудволкны стикер 5,000, усны сурталчилгааны материал 10,000 ш, аяга 130 ш, кофены аяганы стикер 30,000 ш зэргийг хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 13 төрлийн **87,130** ширхэг сурталчилгааны материалыг хэвлүүлэн иргэд, олон нийтэд түгээсэн.

Мөн Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл 541 хувь, Сэтгэхүй хөгжүүлэх бодлого /гарын авлага/ 250 хувь, 2022 оны хагас жилийн тайлан 10 хувь, “Шударга ёс” сэтгүүл 1,169 хувь, “Шударга тоглоё” буддаг ном 1,000 хувь, нийт 5 төрлийн 2,970 хувь эмхэтгэл, гарын авлага, сэтгүүл, ном хэвлүүлж түгээсэн бол тараах материал болох “110 флаш” 244 ш, “12 төрлийн хориглолт, хязгаарлалт” брошюр 13,200 ш, “110 карт холдер” 582 ш, 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан дэвтэр 1,003 ш, стикер наалт 10,000 ш, аяны сурталчилгааны хуудас 200 ш, “Нэгдье-110” зурагт хуудас 2,300 ш, шүүхэд итгэх иргэдийн

итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зурагт хуудас 7,000 ш, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарын сурталчилгаа бүхий бал 128, нийт 9 төрлийн **34,657** ширхэг постер, зурагт хуудас зэрэг сурталчилгааны материалыг олон нийтэд түгээв.

АВЛИГА ГЭДЭГ НЬ ЗӨВХӨН БЭЛЭН МӨНГӨ СОЛИЛЦОХ ҮЙЛДЭЛ БИШ

1 Хахуульдах /хахууль өгөх, өгөхийг шаардах /	6 Ашиг сонирхлын зөрчил үүсгэх
2 Албаны бүрэн эрх, эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	7 Өөрт болон бусдад эдийн болон эдийн бус давуу байдал олгох
3 Танил талаа ашиглах	8 Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
4 Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах	9 Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
5 Нэгдмэл сонирхолтой эсвэл өөрийнхөө хамаарал бүхий этгээдүүдийг ашиглах	10 Бусад

! 2022 онд АТГ-т нийт 1520 хэрэг бүртгэлд, мөрдөн байцаалтын хэргийн **1011 хэрэг буюу 55.9 хувь нь Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан** хэрэг шалгагдсан.

Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал 110

АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗӨВЛӨЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ
АЖЛЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
ЛОГО

Урьдчилан сэргийлэх соён
гэгээрүүлэх хэлтэс

ШУДАРГА ӨС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД

Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлсэн **2 их наяд 374 тэрбум төгрөгөөр** юу хийж болох байсан бэ?

“YINLONG ENERGY”
КОМПАНИЙН ЦАХИЛГААН АВТОБУС
500,000,000.00 төгрөг
Эх сурвалж: <https://news.mn/l/2264358/>
2020-02-20

4,748 ширхэг

(36 хүний суудалтай цахилгаан автобус)

110

Авлигыг мэдээлэх утас

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Авлигатай тэмцэх газар нь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан, нөхцөлийн талаарх бодлогын болон зорилтот дараах судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна:

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2023 оны Шударга байдлын үнэлгээний дүн **76.6** оноотой гарж, өмнөх оны үнэлгээний дүнгээс **2.7** оноогоор нэмэгдсэн байна. 2023 онд гадаад шударга байдлын үнэлгээ **2.3** оноогоор, бодлогод оролцогчдын үнэлгээ **4.7** оноогоор нэмэгдсэн нь үнэлгээний нийт дүнд нөлөөлсөн байна.

Яамдын үнэлгээг 2022 онтой харьцуулахад **4.0** оноогоор нэмэгдсэн ба үнэлгээг эрэмбэлэхэд талаас илүү нь буюу **12** яам улсын дунджаас дээгүүр, **4** яам улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

14 яамны үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад өссөн, **2** яамны (Эдийн засаг, хөгжлийн яам, Соёлын яам) үнэлгээ буурсан байна. Агентлагуудын үнэлгээ 2022 онтой харьцуулахад **2.8** оноогоор сайжирсан ба нийт **33** агентлаг судалгаанд хамрагдсанаас

19 агентлагийн үнэлгээ дунджаас дээгүүр, **14** агентлагийн үнэлгээ дунджаас доогуур түвшинд байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд **13** нь улсын дунджаас дээгүүр, **9** нь доогуур үнэлгээ авсан байв. Үнэлгээг 2022 онтой харьцуулахад **15** байгууллагынх нэмэгдэж, **7** байгууллагынх буурчээ. Нийслэлийн **9** дүүргийн хувьд Сүхбаатар дүүргийн ЗДТГ хамгийн өндөр үнэлгээ авсан бол Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ хамгийн бага үнэлгээ авчээ. **5** дүүрэг дундаж үнэлгээнээс дээгүүр үнэлэгдсэн бол **4** дүүрэг дунджаас доогуур үнэлэгджээ.

Судалгаанд хамрагдсан нийт иргэд, төрийн албан хаагч, бодлогод оролцогчдын **74.2** хувь нь Монгол Улсад авлига түгээмэл буюу ихээхэн түгээмэл байна гэж үзжээ. Энэхүү үзүүлэлт 2021 оноос хойш тасралтгүй нэмэгдэж байна. 2023 онд Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийг шүүх тэргүүлсэн байна. Үүний дараа газрын алба, эрүүл мэндийн байгууллага, гаалийн байгууллага, улс төрийн нам эрэмбэлэгдсэн байна. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад эрүүл мэндийн байгууллагын үнэлгээ **2.4** хувиар буурсан ба шүүх байгууллагын үнэлгээ **8.5** хувиар өсжээ.

Авлигын эсрэг хууль:

18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.7.төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.

УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА

2008-2017 онд улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн тус судалгааг Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа болон Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн авлигын талаарх төсөөллийн судалгаа гэсэн хоёр тусдаа судалгаа болгон хараат бус судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2023 оны судалгааны дүнгээр Монгол Улс дахь улс төрийн хүрээний авлигын төсөөллийн 2023 оны нэгдсэн индекс **3.96** гарч өмнөх оноос **0.22** пунктээр, сүүлийн таван жилийн дунджаас **0.05** пунктээр буурсан эерэг үзүүлэлт гарсан. Гэвч судалгааны дүн сүүлийн 5 жилийн дунджаар тодорхой өөрчлөлт ажиглагдаагүй бөгөөд шинжээчид улс төрийн хүрээний авлигын тархалт нэмэгдэж, илүү далд, илүү их хэмжээтэй, илүү хор уршиг өндөртэй болж байгааг хүлээн зөвшөөрч буй бөгөөд дээд түвшний авлига буурахгүй байна гэж үзсэн. Цаашид судалгааны үр дүнг нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулж, судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2023 оны судалгааны дүнгээр шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын төсөөллийн индекс **3.9** гарч өмнөх оны үзүүлэлтээс **0.14** пунктээр буурсан байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

“Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн хараат бус, бие даасан байдал” сэдэвт илтгэлийн уралдаан зарлаж, эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Уралдааны нэгдүгээр шатанд **17** бүтээл оролцоноос шилдэг **6** бүтээлийг шалгаруулж, хоёрдугаар шатны хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч Б.Эрдэнэбатын “Мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрөл, тулгамдсан асуудал”, Үндэсний тагнуулын академийн тэнхимийн эрхлэгч, дэд профессор Ч.Доржсүрэнгийн “Мөрдөгчийн хараат бус байдлыг хуульчлан баталгаажуулах нь”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Буянбатын “Авлигын гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нь” сэдэвт илтгэл шилдэг бүтээлээр шалгарсан.

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА



Хүүхдийн шударга байдлын 2023 оны судалгааг **21** аймаг болон нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн **8,693** сурагч, **1,312** багш, албан хаагч, **3,747** эцэг, эхийг хамруулан зохион байгууллаа. Судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин **3.97** оноотой гарлаа. Энэ нь 2022 оны түвшнээс **0.01** пунктээр өссөн үзүүлэлт юм.

БУСАД СУДАЛГАА

Дээр дурдсан давтамжит судалгаанаас гадна дараах судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна:

- “Түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох судалгаа”
- “Яллахгүйгээр хөрөнгө хураах нь хөрөнгө буцаах хэрэгсэл болох нь”
- “Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023)”-ний гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ
- “Хуурамч эмийн борлуулалт, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”
- “Төрийн албан хаагчтай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн нөхцөл байдал”
- “Авлигын эрсдэл өндөртэй байж болзошгүй салбар, байгууллагын судалгаа”
- “Мөрдөн шалгах ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглаж мэдүүлэг авч буй гадаад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт”

2020-2022 онд зохион байгуулсан дараах судалгааны тайланг судалгааны багаас хүлээн авч, эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан судалгааны дүн, ач холбогдлыг танилцуулах уулзалт зохион байгуулав. Үүнд:

- ШУА-ийн Философийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024), төлөвлөгөө”;
- “Төрийн бодлогын шинжилгээний хүрээлэн” ТББ-ын гүйцэтгэсэн “Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)”-ны тайлан;
- Шихихутуг их сургуулийн судалгааны багийн гүйцэтгэсэн Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн өнөөгийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмж бүхий үнэлгээ, санал боловсруулах судалгааны ажил;
- “Системийн динамик загварчлал” ТББ-ын гүйцэтгэсэн “Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн системийн динамик загвар” судалгааны тайлан.

АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагаас АНУ-ын Төрийн департаментын дэргэдэх Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах асуудал эрхэлсэн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” төсөл (2021-2024)-ийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023

авлига, ашиг сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа, түүний хэлбэр, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тодорхойлон үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чиглүүлэх зорилго бүхий Авлигын эрсдэлийн үнэлгээний шинжээч бэлтгэх сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, нээлттэй зарласны дагуу 76 иргэн хүсэлт ирүүлснээс 2 шатны сонгон шалгаруулалтыг хийж, **50** иргэнийг сонгон сургалтад хамруулсан. Тус байгууллагын 6 албан хаагч болон Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын эрх бүхий албан тушаалтнуудыг сургагч багшаар сургаж бэлтгэв.

Энэ арга хэмжээний хүрээнд төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалд суурилсан гарын авлагыг боловсруулж хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгосон.

Эрсдэлийн шинжээчээр бэлтгэгдсэн **2** баг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар болон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын авлигын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгууллаа.



ХЭВЛЭЖ ТҮГЭЭСЭН НОМ, СЭТГҮҮЛ, ГАРЫН АВЛАГА

Сэтгүүл, гарын авлагыг хэвлэн түгээлээ:

- Базелийн Засаглалын хүрээлэнгээс гаргасан “Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгийг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага”;
- “Шударга ёс” сэтгүүлийн 2022/02 (24), 2023/01 (25), 2023/02 (26) дугаарууд;
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр;
- Авлигатай тэмцэх газраас 2020-2022 онд зохион байгуулсан судалгааны ажлын тайлангийн эмхэтгэл;
- “Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ” сургалтын гарын авлага;



ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЛБАН ТУШААЛТНЫ ХАСХОМ-ИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн, мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт **124** байгууллагын **49,680** (цахимаар **44,283**, хэвлэмэл байдлаар **5,396**) мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд **49,679** буюу **99.9** хувь нь мэдүүлгээ гаргаж баталгаажуулсан байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад **343** албан тушаалтнаас **322** албан тушаалтан хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна (**20** албан тушаал сул байсан).

2022 онд ХАСХОМ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагчийн тоо өмнөх оноос **2,124** нэгжээр нэмэгдсэн.

Тус онд Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоосон, Цэргийн тагнуулын газар, Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын Монголын хэсэг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн

Авлигын эсрэг хууль:

10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

11.1.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;


11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяанд Ойн газар, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Олимп, нийтийн биеийн тамирын үндэсний хороо байгуулагдаж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-д нэгтгэсэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт харьяалагдаж байсан Цөмийн энергийн комиссын Ажлын алба Боловсрол, шинжлэх ухааны яаманд, Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүс Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжсэн болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотой байна. 2022 онд Авлигатай тэмцэх газраас Эрүүл мэндийн яам, түүний харьяа байгууллагуудын албан тушаалын чиг үүрэгт хийсэн дүн шинжилгээний дүнд Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудыг бүрэн хамруулсан нь үүнд нөлөөлсөн байна.

ХАСХОМ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын **15,821** буюу **32** хувь нь төрийн тусгай, **12,824** буюу **26** хувь нь төрийн захиргааны, **7,738** буюу **16** хувь нь улс төрийн, **7,459** буюу **15** хувь нь төрийн үйлчилгээний удирдах, **2,979** буюу **6** хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах, **323** буюу **0.6** хувь нь төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах, **38** буюу **0.1** хувь нь төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, **2,498** буюу **5.0** хувь нь бусад албан тушаалтан байна.

Мэдүүлэг гаргагч, төрийн албан тушаалын ангиллаар



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

23.3.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

24.1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

24.1.4.аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;


24.1.5.энэ хуулийн 24.1.2-24.1.4-т зааснаас бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

24.2.Энэ хуулийн 24.1.4–24.1.5-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

Мэдүүлэг гаргагчдын **28,176** буюу **57.0** хувь нь Улаанбаатар хотод (2022 онд **55** хувь байсан), **21,503** буюу **43.0** хувь нь орон нутагт (2022 онд **45** хувь байсан), мөн **14,904** буюу **30.0** хувийг ахлах мэргэжилтэн болон удирдах, **34,775** буюу **70.0** хувь нь гүйцэтгэх албан тушаалтан эзэлж байна.

Хөвсгөл аймгаас **1,409** мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгаас өндөр үзүүлэлт болж байна.

Мэдүүлэг гаргагчийн тоо, аймгаар



Авлигын эсрэг хууль:

10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ.

Дээрх тайлан, мэдээний дүнгээс үзэхэд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан “хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт”-ийн талаар мэдүүлсэн **904**, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан “ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл” гаргасан **41,276**, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “ашиг сонирхлын зөрчил

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

8.1.Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

8.2.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

үүссэн тухай мэдэгдэл” гаргасан **346**, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд бичгээр тайлбар гаргасан **65** мэдүүлэг гаргагч тус тус бүртгэгдсэн байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2022 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг <http://www.хасхот.iaас.mn> цахим хуудсанд 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан.

СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох хүрээнд **44,283** албан тушаалтны ХАСХОМ-ийн мэдээлэлд эрсдэл тооцлоо.

Эрсдэлийн дүн шинжилгээгээр дунд болон түүнээс дээш эрсдэлтэй **7,213 (16.3 хувь)**, түүний дотор дараах байгууллагын мэдүүлэг гаргагчдын эрсдэл өндөр байгаа дүн гарсан:

- Дорнод аймгийн ИТХ
- Архангай аймгийн ИТХ
- Монголбанк
- Увс аймгийн ИТХ
- Гадаад харилцааны яам
- Өмнөговь аймгийн ИТХ
- Нийслэлийн ЗДТГ
- Зам, тээврийн хөгжлийн яам
- Өмнөговь аймгийн ЗДТГ
- Өвөрхангай аймгийн ИТХ
- Баянхонгор аймгийн ЗДТГ
- Нийслэлийн ИТХ
- Эрүүл мэндийн яам зэрэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгүүлсэн **1,647** этгээдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд **49** мэдүүлэг гаргагч авлигын гэмт хэрэгт ял шийтгүүлснээс төрийн жинхэнэ албан хаагч **13** байсан. Иймд энэхүү судалгаанд үндэслэн Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан шаардлагыг хангахгүй байгаа албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөх шаардлагатай мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандаж хүргүүлснээр нэр бүхий албан хаагчдыг албан тушаалаас нь чөлөөлүүлэв.

Мэдүүлгийн системд үндэслэн ХАСУМ-ийн хяналтаар илт ашиг сонирхлын зөрчилтэй болон ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүйг анхааруулсан этгээдийг нэр дэвшсэн албан тушаалд томилсон талаарх судалгааг хийлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 2022 оны **14,695**, 2023 оны нэгдүгээр улирлын **4,314**, нийт **19,009** этгээдийн ХАСУМ-т дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээнд үндэслэн мөн хуулийн холбогдох хэсэгт, өөрөөр хэлбэл, ХАСУМ хянуулалгүйгээр нийтийн албанд томилсон тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх саналыг уламжилснаар Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөлт оруулсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20¹ дугаар зүйлийн 20^{1.2} дахь заалт 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөнтэй холбогдуулсан уг хориглолтод

Төрийн албаны тухай хууль:

22 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага
22.1.3.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;

хамаарах этгээдийн судалгааг гаргаж дүн шинжилгээ хийв.

Биеийн тамир, спортын хороонд мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтыг хийж, нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлж, зөрчил гаргасан **3** албан тушаалтанд хариуцлага тооцуулсан. ХАСХОМ-тээ **10 сая**, түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгө, орлого мэдүүлсэн **293** албан тушаалтны судалгааг гаргаж, холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

2012.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, нийтлэг зөрчлийг тодорхойлох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна. Тухайлбал,

Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Бүх шатны шүүхийн Тамгын газар, Улсын ерөнхий прокурорын газар, Төрийн албаны зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Соёлын яам, түүний харьяа байгууллага, Боловсрол, шинжлэх ухааны яам, түүний харьяа байгууллага, Цэргийн тагнуулын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний харьяа байгууллага, Татварын ерөнхий

газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн ИТХ, Нийслэлийн ЗДТГ, түүний харьяа байгууллага, Архангай аймгийн ИТХ болон ЗДТГ, Сүхбаатар аймгийн ИТХ, Баянгол дүүргийн ЗДТГ, Нийслэлийн нутгийн захиргааны 21 байгууллага, Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Хадгаламжийн даатгалын корпорац, Монгол Улсын Боловсролын их сургууль, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Биокомбинат” ТӨХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Эрдэнэс Тавантолгой” ХХК зэрэг **41** байгууллагын мэдүүлэг гаргагч албан тушаалтад ХАСУМ, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал, мэдэгдэл тайлбар гаргах талаар **32** удаагийн сургалт зохион байгуулж, **11,497** мэдүүлэг гаргагч хамрагдсан байна.

2023 онд шинээр томилогдсон **566**, төв байгууллагын **111**, Боловсрол, шинжлэх ухааны яам, түүний харьяа байгууллага, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллага, Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг байгууллагын **108** ЭБАТ-д “ХАСУМ,

ХАСХОМ мэдүүлэх тухай”, “Мэдэгдэл, тайлбар гаргах асуудал”, “ЭБАТ-ы үйл ажиллагаа, цахим системийн ашиглалт” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор **2,588** ЭБАТ хамрагдсан байна.


Хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаар телевиз, сонин, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн бусад хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр дамжуулан тогтмол мэдээллээр хангаж ажиллав.

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ (ХАСХОМ)-ИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2023 онд шинээр хүлээн авсан **564**, өмнөх оны үлдэгдэл **21**, нийт **585** албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах ажил үргэлжилж байна. Шийдвэрлэлт **82.7** хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, **0.3** хувиар өссөн байна.

Хянан шийдвэрлэсэн **484** мэдүүлгийн **388** буюу **80.1** хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, **64** буюу **13.2** хувийг иргэний гомдол, мэдээллээр, **32** буюу **6.7** хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.


ХАСХОМ-ийн хяналт шалгалт, оноор



Хяналт шалгалтаар нийт **34** албан тушаалтанд дараах хариуцлага тооцуулсан:

- Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар **5** мэдүүлэг гаргагчид сануулах;
- Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.2-т зааснаар **9** мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар **17** хувиар бууруулах;
- Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.3-т зааснаар **17** мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар, тодорхой хувиар бууруулах;
- Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.4-т зааснаар **3** албан тушаалтанд төрийн албанаас халах.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага, оноор



Хяналт шалгалтаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон **60** мэдүүлэг гаргагчийн **32**-ыг Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан буюу Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үндэслэлээр, **28**-ыг нь авлигын гэмт хэргийн бусад үндэслэлээр тус тус шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс болон Гүйцэтгэх ажлын хэлтэст шилжүүлсэн байна.

Шалгалтаар **5** мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Татварын ерөнхий газарт шилжүүлэн татварын хяналт шалгалтаар **8.4** тэрбум төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт **637** сая төгрөгийн нөхөн төлбөр, торгууль, алданги ногдуулсан.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан **980**, өмнөх оны үлдэгдэл **30**, нийт **1,010** гомдол, мэдээллийг хянан шалгахаас **957** гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо **53** гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт **95.0** хувьтай байна.

Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Шийдвэрлэсэн байдал		Дүн	Хувь
Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн		86	9.0
Зөрчил илрээгүй		405	42.3
Хуульд заасан үндэслэлээр хариу өгч буцаасан		84	8.8
Зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн		1	0.1
Бусад		38	4.0
Харьяаллын дагуу шилжүүлсэн	Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар МШХ-т шилжүүлсэн	89	9.3
	Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар ГАХ-т шилжүүлсэн	19	2.0
	УССГХ-т шилжүүлсэн	66	6.9
	Төрийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн	169	17.6
Нийт		957	100.0

Өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг авч үзэхэд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулийг зөрчсөн талаарх тодорхой зөрчлийг тогтоон шийдвэрлэж, улмаар зөрчил гаргасан нийт **39** албан тушаалтанд холбогдох хариуцлагыг тооцуулсан байна.

Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар Мөн хяналт шалгалтын хүрээнд хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, талаар Боловсрол шинжлэх ухааны яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Баянгол, Чингэлтэй дүүргийн Засаг дарга, Баян-Өлгий, Хөвсгөл, Увс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар зэрэг нийт **82** байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, чиглэл хүргүүлж, үр дүн биелэлтийг тооцон ажилласан.

Хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, **327** нэгжээр буюу **50** хувиар, хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл **295** нэгжээр буюу **44.5** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт гомдол, мэдээллийн **53.8** хувийг Улаанбаатар хотоос, **46.2** хувийг орон нутгаас ирүүлсэн байна. Дараах аймгуудаас ирсэн гомдол, мэдээллийн тоо орон нутгаас ирсэн нийт гомдол, мэдээллийн дүнд хамгийн өндөр хувийг эзэлж байна:

- Баян-Өлгий аймгаас **75** буюу **7.4** хувь;
- Сэлэнгэ аймгаас **52** буюу **5.1** хувь;
- Орхон аймгаас **47** буюу **4.7** хувь.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар гомдол гаргагчдын **47.0** хувьд нь албан бичгээр, **53.0** хувьд нь амаар (утсаар, цахим шуудангаар) хариу өгсөн байна.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулга

Гомдол, мэдээллийн агуулга	Хувь
Хууль бус томилгоо хийсэн	26
Хууль бус шийдвэр гаргаж, бусдад давуу байдал олгосон	25
Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан	21
Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн	20
Бусад	8

Энэхүү үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон зөрчил **2.0** хувиар, хууль бус томилгоо хийсэн зөрчил **1.0** хувиар өсч, бусад зөрчил дунджаар **1.0** хувиар буурсан байна.

НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН ЭТГЭЭДИЙН ХАСУМ-ИЙН ХЯНАЛТ

2023 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **16,487** этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас **16,331** этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, хариуг холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд **156** мэдүүлэг хянагдаж байна.

ХАСУМ-ийн шийдвэрлэлт

Үзүүлэлт		2022	2023	Өөрчлөлт	Хувь
Нийт хянан шийдвэрлэсэн		14,695	16,331	+1,636	11.1
Үүнээс:	Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	13,616	15,357	+1,741	12.8
	Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан	918	724	-194	18.9
	Илт Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон	37	22	-15	59.5
	Хууль, журамд заасан үндэслэлээр буцаасан	124	228	+104	83.9

Улсын Их Хурлаас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан (Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ)-ыг зөрчсөн томилох эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр өөрчлөлт оруулсан.

Энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойших хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг тус байгууллагаар хянуулалгүйгээр томилж, хууль зөрчсөн **34** томилох эрх бүхий удирдах албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах шаардлага хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

3 дугаар зүйл. ... мөн зүйлийн 29.2.2 дахь заалтын "21.4-т" гэснийг "21.4, 23.5-д" гэж,

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ


2023 онд өмнөх оны **141**, шинээр хүлээн авсан гэмт хэргийн талаарх **2,015**, нийт **2,156** гомдол, мэдээллийг хүлээн авснаас **427** гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн талаарх **1,670** гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл

Үзүүлэлт	2022	2023	Өөрчлөлт	Хувь
Нийт хүлээн авсан	1,841	2,156	+315	17
Үүнээс:				
Өмнөх оны үлдэгдэл	125	141	+16	13
Хуульд заасан үндэслэлээр харьяалах төрийн байгууллагад шилжүүлсэн	336	427	+91	27
Бүртгэлд оруулан шалгасан	1,413	1,670	+257	18

Хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл жил бүр өсөх хандлагатай байна:


Хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо, оноор



Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл:

Төрийн улс төрийн **277**, төрийн захиргааны **510**, төрийн тусгай **729**, төрийн үйлчилгээний **148**, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн **235**, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын **116** байна.

Гомдол, мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал, оноор



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан **1,670** гомдол, мэдээллээс **701** гомдол, мэдээлэл буюу **41.9** хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, **870** гомдол, мэдээлэл буюу **52.1** хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, **44** гомдол, мэдээлэл буюу **2.6** хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, **55** гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт **96.7** хувьтай байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, оноор



Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан **1,670** гомдол, мэдээллийн **987** буюу **59.1** хувийг Улаанбаатар, **683** буюу **40.9** хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.


ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын **2,183** үйлдэлтэй, **1,402** холбогдогчтой, **1,837** хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг 2022 онд **1,520** хэрэг шалгасантай харьцуулбал **21.0** хувиар өссөн байна.

Нийт шалгасан хэргийн **325** буюу **17.7** хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, **544** буюу **29.6** хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, **57** буюу **3.1** хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, **132** хэргийг нэгтгэн шалгаж, **12** хэргийг түдгэлзүүлж, одоо **767** эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн **690** хэрэг, мөрдөн байцаалтын **77** хэрэг байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт **57.6** хувьтай, өмнөх оны мөн үеэс **5.4** хувиар өссөн үзүүлэлттэй байна. Шүүхээр **192** хэрэг шийдвэрлэгдсэн байна.

Хэргийн шийдвэрлэлт, оноор




Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйлээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-д заасан гэмт хэрэг **1,011** буюу **55.9** хувь,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл (Хахууль авах)-д заасан гэмт хэрэг **239** буюу **13.2** хувь,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл (Хахууль өгөх)-д заасан гэмт хэрэг **138** буюу **7.6** хувь,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах)-д заасан гэмт хэрэг **22** буюу **1.2** хувь,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих)-д заасан гэмт хэрэг **52** буюу **2.9** хувь,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах)-д заасан гэмт хэрэг гэмт хэрэг **34** буюу **1.9** хувь,
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах)-д заасан гэмт хэрэг **37** буюу **2.0** хувь,
- Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл (Эрүү шүүлт тулгах)-д заасан гэмт хэрэг **15** буюу **0.8** хувь,
- Бусад хэрэг **258** буюу **14.3** хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн **56** буюу **4.7** хувийг төрийн улс төрийн, **127** буюу **10.7** хувийг төрийн захиргааны, **103** буюу **8.7** хувийг төрийн тусгай, **84** буюу **7.1** хувийг төрийн үйлчилгээний, **814** буюу **68.8** хувийг бусад этгээд эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан, оноор




ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

2023 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас **845,797,805,525** (найман зуун дөчин таван тэрбум, долоон зуун ерэн долоон сая, найман зуун таван мянга таван зуун хорин тав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **238,689,979,559** (хоёр зуун гучин найман тэрбум, зургаан зуун наян есөн сая, есөн зуун далан есөн мянга таван зуун тавин ес) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг **17,137,615,448** (арван долоон тэрбум, нэг зуун гучин долоон сая, зургаан зуун арван таван мянга, дөрвөн зуун дөчин найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.



Нийт учирсан хохирлын **28.2** хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, хахуулийн **8,680,730,871** (найман тэрбум зургаан зуун наян сая долоон зуун гучин мянга найман зуун далан нэг) төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, оноор



Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол:



Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн:



Битүүмжлэн хамгаалсан эд хөрөнгө болон бэлэн мөнгө:



ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2022 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс **188** эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2023 онд **192** хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс дурдвал:

- Хөгжлийн банкны эрх бүхий 84 албан тушаалтанд холбогдох;
- Баянхонгор аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт холбогдох;
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот дахь консулын газрын ерөнхий консулаар ажиллаж байсан “М” нарт холбогдох;
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр)-ийн Гадаад худалдааны хэлтсийн дарга “А”-д холбогдох;
- “Эрдэнэс силвер” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал “М” нарт холбогдох;
- “Багануур” ХК-ийн гүйцэтгэх захирал “Н” нарт холбогдох;
- Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч “Д”-т холбогдох;

- Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын замын ашиглалт, засварын хэлтсийн дарга “О” нарт холбогдох;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн дарга “У”-т холбогдох;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга “Ч”-д холбогдох;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн дарга “Э” нарт холбогдох;
- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Архив, лавлагааны тасгийн дарга “Б”-т холбогдох;
- Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга “Э”-т холбогдох;
- Хил хамгаалах ерөнхий газрын нууцын албаны ахлах ажилтан “Т” нарт холбогдох;
- Худалдаа хөгжлийн банкны Хуулийн газрын захирал “Б”-д холбогдох;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч “Н” нарт холбогдох;
- Татварын ерөнхий газрын Татварын орлогын газрын татварын улсын байцаагч “Э” нарт холбогдох;
- Гаалийн ерөнхий газрын Гашуунсухайт дахь гаалийн газрын зөрчлийн улсын ахлах байцаагч “Э” нарт холбогдох;
- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Цогтцэций салбарын дарга “Д” нарт холбогдох;
- “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Маркетинг борлуулалтын хэлтсийн борлуулалтын ахлах мэргэжилтэн “Б” нарт холбогдох зэрэг хэргүүд анхан шатны шүүхээр тус тус шийдвэрлэгдээд байна.

ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ

- Улсын Ерөнхий Прокурорын газрын прокурорын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 4/04 дугаартай тогтоолыг үндэслэн Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/101, А/119, А/326 дугаартай тушаалаар нүүрс олборлолт, экспорт, боомтын нүүрсний тээвэрлэлт, төлбөртэй холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн **76** хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас **16** хэргийн мөрдөн шалгах ажиллагааг дуусган шүүхэд шилжүүлэх, **10** хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэх, **13** хэргийг хаах саналтай Нийслэлийн прокурорын газрын хяналтад шилжүүлсэн.
- Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих прокурорын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 4/02 тоот тогтоолын дагуу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/34, А/134 дугаар хамтарсан тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын зээлийн сангаас төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүд хууль бус тэтгэлэг авч, эргэн төлөөгүй, мөн тэтгэлгийн мөнгийг хувийн дансаар авч завшсан, мөнгө угаасан байж болзошгүй гэх хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажлын хэсэг байгуулагдсан ба мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.



ХОЁР. АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг гадаадын болон дотоодын судалгаа гэсэн хоёр чиглэлээр боловсруулсан. Эдгээр судалгаа, үнэлгээ бүр олон дэд үзүүлэлтийг хамардаг боловч дэлгэрэнгүй тайлантай тухайн судалгааны эх сурвалжаас танилцах боломжтой тул энд зөвхөн гол, ерөнхий үр дүнг оруулсан болно.

ГАДААД СУДАЛГААНЫ ҮР ДҮН




2.1 АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС

Транспэрэнси Интернэшнл (ТИ) байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс¹ (АТИ)-ийн 2023 оны дүнгээр 33 оноо авж, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Уг индексээр Монгол Улс 2012-2023 онд дунджаар 36.17 оноо авсан.

Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу 43 гараад байна (боломжит 100 онооноос). Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна.

Мөн шүүхийн тогтолцоо суларч буй дэлхий нийтийн чиг хандлага нь нийтийн албан тушаалтны хариуцлагыг бууруулж, улмаар авлига цэцэглэх боломжийг олгож байгааг ТИ байгууллага онцлон тэмдэглэжээ.

Авлигын төсөөллийн индекс, оноор



Монгол Улсын АТИ-ийг тооцоход олон улсын 10 орчим судалгаа, индексийг ашигладаг бөгөөд тэдгээрт дараах асуудлыг үнэлдэг:

- Төрийн удирдах албан хаагчид институцийг удирдах, төрийн албан хаагч өөрсдийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээдэг эсэх
- Иргэний нийгэм төрийн үйл ажиллагааны мэдээллийг авах боломжтой эсэх
- Төрийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигладаг эсэх
- Бизнес эрхлэгчид авлигад өртдөг эсэх
- Төсвийн хөрөнгийг шамшигдуулж, зориулалтын бусаар зарцуулдаг эсэх
- Төрийн албан хаагч авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээдэг, олон нийт шүүмжилдэг эсэх
- Засгийн газраас авлигатай үр дүнтэй тэмцдэг, авлигатай тэмцэх механизмтай эсэх
- Иргэд авлигатай тулгардаг эсэх


¹ <https://www.transparency.org/en/cpi/2023>

- Гүйцэтгэх, шүүх, цэрэг цагдаа, хууль тогтоогч нь эрх мэдэл, албан тушаалаа хувийн сонирхлын үүднээс ашигладаг эсэх
- Улс төрийн хүрээнд авлига байдаг эсэх
- Төсвийн хуваарилалт, захиран зарцуулалтад тодорхой процесс, хариуцлагын тогтолцоо байгаа эсэх
- Төсвийн хөрөнгийг сайд, албан тушаалтнууд хувийн, эсхүл улс төрийн намын зориулалтаар зарцуулдаг эсэх
- Хариуцлага, хяналтгүй зарцуулах боломжтой тусгай сан байдаг эсэх
- Мэргэжлийн төрийн албан хаагчид байдаг эсэх, эсхүл ихэнх төрийн албан хаагчдыг засгийн газраас шууд томилдог эсэх
- Төсвийн хөрөнгийн захиран зарцуулалтыг аудит хийх бие даасан байгууллага байдаг эсэх
- Сайд, төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх хараат бус шүүх байдаг эсэх
- Гэрээ байгуулах, давуу байдал бий болгох зорилгоор хахууль өгөх заншил байдаг эсэх гэх мэт.

2.2 ДЭЛХИЙН АВЛИГЫН ХЭМЖҮҮР

ТИ байгууллагаас гаргадаг Дэлхийн авлигын хэмжүүр² (Global Corruption Barometer) судалгаа нь иргэд хахуультай нүүр тулж байгаа эсэх, тухайн улсад авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгаа, мөн засгийн газар нь авлигатай үр дүнтэй тэмцэж чадаж байгаа эсэх талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа юм. Энэ судалгааны 7 (2010 он), 8 (2013 он), 10 (2020 он) дахь дугаарт манай улсыг хамруулан судалсан байх бөгөөд үр дүнгээс харахад иргэд жил ирэх бүр авлигын түвшин өссөн гэж үзэх нь багасч, буурсан гэж үзэх нь нэмэгдсэн байна. Гэхдээ 2010 оны судалгаанд “Өнгөрсөн 3 жилийн хугацаанд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэж асуусан бол 2013 онд “өнгөрсөн 2 жилд”, 2020 онд “өнгөрсөн 1 жилд” гэж асуужээ.

Судалгаанд оролцсон иргэд “Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэдэг асуултад хариулсан байдал, хувиар



Харин авлига хаана хамгийн түгээмэл байна вэ гэдэг дээр эхний 5 байрт дараах хариултыг өгсөн байна:

² <https://www.transparency.org/en/gcb>

Авлига түгээмэл салбар, албан тушаалтан, хувиар


2010	2013	2020
Парламент (82%)	Төрийн албан хаагч (77%)	Парламентын гишүүн, ИТХ-ын төлөөлөгч (43%)
Улс төрийн нам (81%)	Шүүх (73%)	Шүүгч (42%)
Шүүх (75%)	Эрүүл мэнд (71%)	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, түүний ажлын албаны ажилтнууд (32%), Бизнес эрхлэгчид (32%)
Цагдаа (67%)	Цагдаа (66%)	Төрийн албан хаагч (30%)
Төрийн албан хаагч (56%)	Улс төрийн нам (65%)	Нутгийн удирдлагын байгууллагын албан тушаалтнууд (29%)

2.3 TRACE-ИЙН ХАХУУЛИЙН ЭРСДЭЛИЙН МАТРИЦ

Трасе интернэшнл байгууллагаас гаргадаг Хахуулийн эрсдэлийн матриц³ (Bribery Risk Matrix) нь улс орнуудын бизнесийн салбар дахь хахуулийн эрсдэлийг Засгийн газар ба бизнесийн харилцаа; Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа; Засгийн газар болон төрийн албаны ил тод байдал; Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх гэсэн багц үзүүлэлтүүдээр хэмждэг. НҮБ, Дэлхийн банк, Гётебургийн их сургуулийн V-Dem институт, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагуудын холбогдох өгөгдлийг нэгтгэн TRACE Интернэшнл байгууллага 2014 оноос эхлэн гаргаж байна. Эрсдэлийг 0-100 оноогоор үнэлэх бөгөөд оноо нэмэгдэх бүр эрсдэл нэмэгдэж байна гэж үзнэ.


Манай улсын хувьд 2014 онд 72 оноотой 156-д эрэмбэлэгдэж байсан бол 2023 онд өмнөх онтой ижил 51 оноо авсан боловч 98 дугаар байрт эрэмбэлэгдэж, 2 байраар ухарсан. 2023 онд “Засгийн газар болон нийтийн албаны ил тод байдал” үзүүлэлт 2 оноогоор нэмэгдсэн боловч “Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа” үзүүлэлт 3 оноогоор, “Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх” үзүүлэлт 1 оноогоор тус тус буурсан байна.

Хахуулийн эрсдэлийн дэд үзүүлэлтийн оноо, оноор



3 <https://www.traceinternational.org/trace-matrix>

Хахуулийн эрсдэлийн матрицын оноо, оноор




2.4 ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСНЫ ИНДЕКС

Улс орны авлигын түвшинд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг бол хууль дээдлэх ёсны хэрэгжилт юм. Мөн авлига, хахуулийн түвшин, эрсдэлийг хэмжихэд олон улсын байгууллагуудын ашигладаг чухал үзүүлэлт бол Дэлхийн эрх зүйн төсөл (World Justice Project) байгууллагаас гаргадаг Хууль дээдлэх ёсны индекс⁴ юм.

Энэ индекс нь Төрийн эрх мэдлийн хязгаарлалт, Авлигаас ангид байдал, Төрийн нээлттэй байдал, Хүний үндсэн эрх, Эрүүгийн болон Иргэний хэргийн шүүх ажиллагаа зэрэг 8 багц, 44 дэд үзүүлэлтийг хэмжиж 0-1 оноогоор үнэлдэг. Манай улсын хувьд 2015 оноос хойш тогтмол 0.53-0.55 оноогоор үнэлэгдсэн.

Хууль дээдлэх ёсны индекс, оноор



Индексийн оноо ийнхүү тогтмол дундаж байгаа нь уг индексээр хэмждэг дараах хүчин зүйлс болон дэд үзүүлэлтэд нөлөөлөх дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна:

Төрийн эрх мэдлийн хязгаарлалт:

1. Төрийн эрх мэдлийг хуулиар үр дүнтэй хязгаарладаг эсэх
2. Төрийн эрх мэдлийг шүүх засаглал үр дүнтэй хязгаарладаг эсэх

⁴ <https://worldjusticeproject.org/about-us/overview/what-rule-law>

3. Төрийн эрх мэдлийг хараат бус аудит, хяналт шалгалтаар үр дүнтэй хязгаарладаг эсэх
4. Төрийн албан тушаалтан буруутай үйлдэлдээ шийтгэл хүлээдэг эсэх
5. Төрийн эрх мэдэл нь төрийн бус хяналт шалгалтад өртдөг эсэх
6. Эрх мэдэл шилжүүлэх үйл явц хуулийн дагуу явагддаг эсэх

Авлигаас ангид байдал:

1. Гүйцэтгэх засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
2. Шүүх засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
3. Цагдаа, цэргийн албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
4. Хууль тогтоох засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх

Төрийн нээлттэй байдал:

1. Нийтлэгдсэн хууль тогтоомж болон төрийн өгөгдөл (мэдээлэл)
2. Мэдээлэл авах эрх
3. Иргэний оролцоо
4. Өргөдөл, гомдлын механизм

Хүний үндсэн эрх:

1. Хуулийн өмнө эрх тэгш байх ба ялгаварлалгүй байдал
2. Хүний амьд явах эрх болон аюулгүй байдлыг үр дүнтэй хамгаалдаг эсэх
3. Яллагдагчтай холбоотой хууль болон түүний эрхийн зохистой хэрэгжилт
4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
5. Шашин шүтэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
6. Хувийн нууц халдашгүй байх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
7. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
8. Хөдөлмөрлөх суурь эрхийг үр дүнтэй хамгаалдаг эсэх

Дэг журам, аюулгүй байдал:

1. Гэмт хэргийг үр дүнтэй хянадаг эсэх
2. Иргэдийн мөргөлдөөнийг үр дүнтэй хязгаарладаг эсэх
3. Иргэд дургүйцлээ илэрхийлэхдээ хүчирхийлэл хэрэглэдэг эсэх

Зохицуулалтын хэрэгжилт:

1. Төрийн зохицуулалт үр дүнтэй хэрэгждэг эсэх
2. Төрийн зохицуулалтыг зүй бус нөлөөлөлгүйгээр мөрдүүлж, хэрэгжүүлдэг эсэх
3. Захиргааны үйл ажиллагаанд шалтгаангүй хүлээгдэл байдаг эсэх
4. Захиргааны үйл ажиллагааг зохих ёсоор явуулахыг эрмэлздэг эсэх
5. Төр хууль бусаар, хангалттай нөхөн төлбөргүйгээр өмчлөх эрхийг хүчингүй болгодог эсэх


Иргэний хэргийн шүүх ажиллагаа:

1. Хүмүүс иргэний хэргийн шүүхэд хандах, үйлчлүүлэх боломжтой эсэх
2. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд ялгаварлан гадуурхалт байдаг эсэх
3. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд авлига байдаг эсэх
4. Иргэний хэргийн шүүхэд төрийн зохисгүй нөлөөлөл байдаг эсэх
5. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд шалтгаангүй хүлээгдэл байдаг эсэх
6. Иргэний хэргийн шүүх ажиллагаа үр дүнтэй хэрэгждэг эсэх
7. Маргаан шийдвэрлэх хувилбарт механизм нь хялбар, шударга, үр дүнтэй эсэх

Эрүүгийн хэргийн шүүх ажиллагаа:

1. Гэмт хэрэг мөрдөн шалгах тогтолцоо нь үр дүнтэй эсэх
2. Эрүүгийн хэргийн шүүх тогтолцоо нь тодорхой хугацаатай бөгөөд үр дүнтэй эсэх
3. Засан хүмүүжүүлэх тогтолцоо нь гэмт зан үйлийг бууруулах үр дүнтэй эсэх
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо нь шударга эсэх
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд авлига байдаг эсэх
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд төрийн зохисгүй нөлөөлөл байдаг эсэх
7. Яллагдагчтай холбоотой хууль болон түүний эрхийн зохистой хэрэгжилт
8. Эдгээр хүчин зүйлс, дэд үзүүлэлт тус бүрийн 2015-2023 оны оноог дараах зурагт үзүүлэв.

Хууль дээдлэх ёсны индексийн хүчин зүйлсийн оноо, оноор



2.5 ДЭЛХИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэлхийн засаглалын үзүүлэлт (Worldwide Governance Indicators) нь Дэлхийн банкны олон жилийн судалгааны хөтөлбөрт үндэслэн 1996-2002 онд хоёр жил тутам, 2002 оноос хойш жил тутам гарч байгаа индекс бөгөөд улс орнуудын засаглалын гүйцэтгэлийг -2.5 (сул) -аас 2.5 (хүчтэй) хүртэлх оноогоор үнэлж, 0 (хамгийн бага)-ээс 100 (хамгийн дээд) хувиар зэрэглэл тогтоон жил бүрийн 9 дүгээр сарын сүүлээр танилцуулдаг.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт Засаглалын зорилтуудын шалгуур үзүүлэлтэд Дэлхийн засаглалын үзүүлэлтээс 1) Иргэдийн дуу хоолой ба хариуцлага, 2) Засгийн газрын үр нөлөө, 3) Зохицуулалтын чанар, 4) Хуулийн засаглал, 5) Авлигын хяналт гэсэн 5 үзүүлэлт болон НҮБ-ын Цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг ашиглахаар заасан тул энэхүү үзүүлэлтүүдийн талаар бага зэрэг дэлгэрүүлэн авч үзлээ.

Засаглалын тухай олон янзын тодорхойлолт байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь хэт явцуу хүрээг хамардаг бол зарим нь хэт өргөн хүрээг хамардаг. Дэлхийн банк эдгээрийн дундын хувилбарыг эрэлхийлж, “тухайн улс оронд эрх мэдлийг хэрэгжүүлж буй уламжлал ба институц” гэж тодорхойлсон. Үүнд (а) засгийн газрыг сонгох, хянах, солих үйл явц; (б) оновчтой бодлогыг үр дүнтэй боловсруулж, хэрэгжүүлэх засгийн газрын чадавх; (в) иргэн ба төрийн хоорондын эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулдаг институцүүдэд хандах тэдний (иргэн ба төрийн) хандлага гэсэн гурван чиглэлд хамаарах тус бүр хоёр хоёр, нийт зургаан хэмжигдэхүүнийг бий болгосон байна⁵.

Мөн уг үзүүлэлтийн суурь мэдээлэлд жил бүр засвар ордог бөгөөд тэдгээрийн зарим нь өмнөх жилүүдийн өгөгдөлд нөлөөлж, үзүүлэлт өөрчлөгддөг. Мөн жил бүрийн үзүүлэлтийн өгөгдлийн багцыг шинэчлэн гаргахдаа “Энэхүү Дэлхийн засаглалын үзүүлэлтүүдийн шинэчлэлт нь өмнөх жилүүдийн өгөгдлийн засваруудыг багтаасан тул энэхүү өгөгдлийн хувилбар нь өмнөх бүх хувилбарын өгөгдлийг орлож байгааг анхаарна уу” гэсэн анхааруулгатай түгээдэг⁶.

Монгол Улсын 2018 оны Дэлхийн засаглалын 6 үзүүлэлтийн үнэлгээ ба эрэмбийн өөрчлөлтийн харьцуулалт, 2019 ба 2021 он

№	Үзүүлэлт	2018 оны Үзүүлэлт				Өөрчлөлт	
		Анх гаргасан (2019)		Шинэчилсэн (2021)		Үнэлгээ	Эрэмбэ
		Үнэлгээ	Эрэмбэ	Үнэлгээ	Эрэмбэ		
1.	Иргэдийн дуу хоолой ба хариуцлага	0.26	57.14	0.24	56.04	-0.02	-1.1
2.	Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал	0.79	74.29	0.83	73.11	+0.04	-1.18
3.	Засгийн газрын үр нөлөө	-0.23	45.67	-0.23	45.19	0	-0.48
4.	Зохицуулалтын чанар	-0.03	54.81	0.02	55.77	+0.05	+0.96
5.	Хуулийн засаглал	-0.27	44.71	-0.27	44.23	0	-0.48
6.	Авлигын хяналт	-0.43	39.90	-0.42	39.90	0.01	0

Дэлхийн засаглалын үзүүлэлтийн үнэлгээг гаргахад үндэслэл болдог эх сурвалжийн багцад жилээс жилд бага зэрэг өөрчлөлт ордог. Зарим эх сурвалжийг шинээр нэмж ашиглах, заримыг нь ашиглахаа болих тохиолдол байдаг. Уг Үзүүлэлтэд цаг хугацааны хувьд хамгийн дээд хэмжээнд харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэхийн тулд эдгээр өөрчлөлтийг бүх онуудын түүхэн өгөгдөлд тогтмол хийдэг учраас жил бүрийн шинэчлэлтээр өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдийг шинээр орлуулдаг байна⁷.

5 Kaufmann D., Kraay A., and Mastruzzi M. The Worldwide Governance Indicators. Methodology and Analytical Issues. 2010. pp. 3-4.

6 <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Documents#wgiDataCrossCtry>

7 Kaufmann D., Kraay A., and Mastruzzi M. The Worldwide Governance Indicators. Methodology and Analytical Issues. 2010. p. 6.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023


Үүнээс шалтгаалан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт тогтоосон суурь түвшнийг 2025, 2030 онд тооцохдоо тухай тухайн үеийн шинэчилсэн өгөгдлийн багцад үндэслэх шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл, “Авлигын хяналт” гэсэн шалгуурын суурь түвшин 2018 онд 39.9 хувь байсан нь цаашид өөрчлөгдөж болзошгүй гэсэн үг.

Монгол Улсын 2012-2022 оны Дэлхийн засаглалын үзүүлэлтүүдийн 2023 оны шинэчлэлтийг танилцуулав:

а) Засгийн газрыг сонгох, хянах, солих үйл явц


Иргэдийн дуу хоолой ба хариуцлага – тухайн улсын иргэд төр засгаа байгуулах, сонгоход оролцох боломж, үзэл бодлоо илэрхийлэх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх ойлголт.

Иргэдийн дуу хоолой ба хариуцлага үзүүлэлтийн хувь, оноор



Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал – улс төрийн сэдэлтэй хүчирхийлэл, терроризм зэрэг үндсэн хуулийн бус, хүчирхийллийн арга хэрэгслээр засгийн газрыг тогтворгүй болгох, түлхэн унагах магадлалын талаарх ойлголт.


Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал үзүүлэлтийн хувь, оноор



(б) Оновчтой бодлогыг үр дүнтэй боловсруулж, хэрэгжүүлэх засгийн газрын чадавх


Засгийн газрын үр нөлөө – төрийн үйлчилгээний чанар, төрийн албаны чанар, улс төрийн дарамт шахалтаас ангид байдлын түвшин, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чанар, мөн засгийн газар эдгээрт чиглэсэн бодлого баримталж буйд итгэх итгэл үнэмшлийн талаарх ойлголт.

Засгийн газрын үр нөлөө үзүүлэлтийн хувь, оноор



Зохицуулалтын чанар – хувийн хэвшлийн хөгжлийг хүлээн зөвшөөрч, дэмжсэн оновчтой бодлого, зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх засгийн газрын чадавхын талаарх ойлголт.


Зохицуулалтын чанар үзүүлэлтийн хувь, оноор



(в) иргэн ба төрийн хоорондын эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулдаг институцүүдэд хандах тэдний (иргэн ба төрийн) хандлага

Хуулийн засаглал – Албан хаагчид итгэл хүлээж, нийгмийн дүрэм журмыг дагаж мөрддөг эсэх, ялангуяа гэрээний хэрэгжилт, өмчийн эрх, цагдаа, шүүхийн чанар, мөн гэмт хэрэг, зөрчилд өртөх магадлалын талаарх ойлголт.


Хуулийн засаглал үзүүлэлтийн хувь, оноор



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023

Авлигын хяналт – Жижиг болон их хэмжээний авлигын хэлбэрээр төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, төрд элитүүд ба хувийн ашиг сонирхлын нөлөөлөл хэр зэрэг байдаг талаарх ойлголт.

Авлигын хяналт үзүүлэлтийн хувь, оноор




2.6 ЦАХИМ ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт Засаглалын зорилтуудын шалгуур үзүүлэлтэд Дэлхийн банкны Дэлхийн засаглалын 5 үзүүлэлтээс гадна НҮБ-ын Цахим засгийн хөгжлийн индексийг ашиглахаар заасан.

Цахим засгийн хөгжлийн индекс⁸ (EGDI буюу E-Government Development Index) нь НҮБ-ын гишүүн орнуудын цахим засаглалын хөгжлийн төлөв байдлыг судалж, 2 жилд нэг удаа зарладаг индекс бөгөөд (1) онлайн үйлчилгээний хамрах хүрээ, чанар (Онлайн үйлчилгээний индекс, OSI), (2) харилцаа холбооны дэд бүтцийн хөгжлийн байдал (Харилцаа холбооны дэд бүтцийн индекс, TII), (3) хүний төрөлхийн капитал (Хүний капиталын индекс, HCI) гэсэн цахим засаглалын хамгийн чухал гурван хэмжигдэхүүний онооны жигнэсэн дундаж юм.

Цахим засгийн хөгжлийн индексийн утга 0.0-ээс 0.25 хүртэл бол “бага”, 0.25-0.50 хүртэл бол “дунд”, 0.50-0.75 хүртэл бол “өндөр”, 0.75-аас 1.00 бол “маш өндөр” гэж үзнэ.

Монгол Улсын Цахим засаглалын хөгжлийн индексийн оноо, оноор



Уг индексийн дэлхийн дундаж 0.6102 бөгөөд манай улсын Цахим засгийн хөгжлийн индекс 2016 оноос хойш тогтмол өсөж байгаа бөгөөд “өндөр” ангилалд багтаж байна.


⁸ <https://publicadministration.un.org/egovkb/en-us/About/Overview/-E-Government-Development-Index>

2.7 ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС

Энэхүү индексийг Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org) байгууллагаас хоёр жил тутамд эрхлэн гаргадаг⁹. Олон улсын төсвийн түншлэл байгууллагын түншээр Нээлттэй нийгэм Форум ажиллаж улсын төсвийн ил тод байдал, төсвийн үйл явцад иргэд оролцох боломжийг олгож буй байдал, төсвийн хяналтын тогтолцооны түвшнийг судалж, дүнг олон нийтэд танилцуулдаг.

Төсвийн ил тод байдлын 61 болон түүнээс дээш оноо нь тухайн улсын иргэд төсвийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнд мэдээлэлтэйгээр оролцоход хангалттай мэдээллийг Засгийн газрын зүгээс нийтэлж буйг¹⁰, харин 41-60 оноо нь хязгаарлагдмал мэдээлэл өгч буйг илтгэнэ.

Монгол Улсын Төсвийн нээлттэй байдлын индекс, оноор




Манай улсын Төсвийн нээлттэй байдлын индекс 2010 оноос хойш буурах хандлагатай байсан бол 2019 оноос сэргэж, 2021 онд 60 оноонд хүрсэн байна.

2.8 ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

АТИ болон Хүний хөгжлийн индекс шууд, хүчтэй хамааралтайг олон судалгаанд дурдсан байдаг. Авлигатай тэмцэх газраас 174 улс орны 2021 оны индексийн өгөгдлийг ашиглан эдгээр үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тооцоход шууд, хүчтэй хамаарал тогтоогдсон. Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн дундаж 2012 оноос хойш 0.735 орчимд (0-1 оноогоор үнэлдэг) хэлбэлзэж байна¹¹. Өөрөөр хэлбэл, Хууль дээдлэх ёсны индексийн нэгэн адил Хүний хөгжлийн индексэд сүүлийн 10 орчим жилд дорвитой өөрчлөлт гараагүй:

Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн оноо, оноор



9 <https://internationalbudget.org/open-budget-survey/open-budget-survey-2021>


10 <https://forum.mn/post/121035>

11 <https://hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG>

2.9 ИННОВАЦИЙН ИНДЕКС

Улс орны авлигын нөхцөл байдалд нийгмийн бүтээлч давхаргын хэмжээ, шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулж буй төсөв, ажилгүйдлийн түвшин, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл зэрэг нийгэм-эдийн засгийн чухал үзүүлэлтүүд нөлөөлдөг. Эдгээрийн үндэс суурь болдог, тогтвортой өсөлтийн чухал элемент бол инновац юм. Манай улс Инновацын индекс (Дэлхийн оюуны өмчийн байгууллага¹²)-ээр 2012 оноос хойш дараах оноог авсан (0-100 оноогоор үнэлдэг):

Монгол Улсын Инновацын индексийн оноо, оноор



Монгол Улсын Инновацийн индекс 2023 онд 0.8 оноогоор нэмэгдэж 132 улс орноос 68 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Инновацын индекс ба нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, Хууль дээдлэх ёсны индекс ба нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь хоорондоо шууд, хүчтэй хамааралтай үзүүлэлтүүд юм.

12 https://www.wipo.int/global_innovation_index/en/2023/

ДОТООД СУДАЛГААНЫ ҮР ДҮН




2.10 ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагын шударга байдлын түвшнийг үнэлдэг бөгөөд тухайн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ, тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын үнэлгээ, бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын үнэлгээнд суурилдаг. Төрийн байгууллагын шударга байдлыг 0-100 оноогоор үнэлдэг бөгөөд 100-д ойртох тусам шударга байдал нэмэгдэж байна гэж үздэг.


2023 оны судалгааны үр дүнгээр Шударга байдлын үнэлгээ 76.6 оноогоор үнэлэгдэж өмнөх оны үнэлгээний дүнгээс 2.7 оноогоор нэмэгдсэн.

Шударга байдлын үнэлгээ, оноор



Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад дараах байдлаар хариулжээ:

Авлигын түгээмэл байдлын талаарх иргэдийн үнэлгээ, оноор




Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 74.2 хувь нь Монгол Улсад авлига “ихээхэн түгээмэл”, “түгээмэл” байдаг гэж хариулжээ. Энэ нь 2021 онтой харьцуулахад 6.6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм. Авлига түгээмэл байгаагийн шалтгааныг тодруулахад “одоогийн нийгэм, төрийн тогтолцоо буруу байгаа учраас түгээмэл байна” гэж үзэж байна. Мөн төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их авдаг, төрийн албан хаагчдын хүнд суртал маш их байдаг учраас хүмүүс ажлаа хурдан бүтээх гэж, цаг хугацаа хэмнэх, одоогийн байгаа хууль дүрэм, журам хэрэгждэггүй, авлига, өгсөн авсан хүнд аль алинд нь хариуцлага тооцдоггүй тогтолцоо байсаар байгаа нь авлига түгээмэл байгаагийн нэг гол илрэл юм гэжээ.

2.11 УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА

2008-2017 онд улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайлан гаргаж байгаад 2018 оноос тус тусад нь судалж байна. Энэ судалгаа нь тухайн салбар, хүрээн дэх авлигын шалтгаан, цар хүрээ, хэлбэр, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх иргэдийн төсөөлөл, хандлагыг тодорхойлдог. Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг 0 (огт үгүй) - 5 (маш их) оноогоор үнэлдэг.


Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2023 оны үр дүнг дараах зурагт харуулав:

Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин, оноор



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2023 оны үр дүнг дараах зурагт харуулав:


Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин, оноор



2.12 ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийн шударга байдлын судалгаа нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, төлөвшил, мөн дүрэм журам сахих болон авлигыг үл тэвчих чадвар, хандлага ямар түвшинд байгааг тодорхойлох зорилготой юм. Хүүхдийн шударга байдлыг 1-5 хүртэлх оноогоор үнэлдэг бөгөөд 5-д ойртох тусам шударга байна гэж ойлгоно. Энэ судалгааны 2012-2024 оны онооны дундаж 3.87 байна.

Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, оноор



Хүүхэд анги дэвших, нас ахих бүр шударга байдлын үнэлгээ буурах, хөвгүүдээс илүү охид шударга байх, хувийн өмчийн сургуулийн сурагчдаас илүү төрийн өмчийн сургуулийн сурагчид шударга байх хандлага тогтмол ажиглагддаг.


2.13 ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС

Энэ судалгааг анх 2010 онд Авлигатай тэмцэх газрын захиалга, НҮБХХ-ийн санхүүжилтээр Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) гүйцэтгэж эхэлсэн бөгөөд төрийн байгууллагын цахим хуудаст хяналт-шинжилгээ хийж “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх, цаашид ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой судалгаа юм.

2018 оноос өмнө тус судалгаагаар 1) Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance), 2) Мэдээллийн найдвартай байдал (Reliability), 3) Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness), 4) Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility), 5) Хэрэглэхэд хялбар байдал Usability) гэсэн үзүүлэлтүүдийг хувиар тооцож, шалгуур үзүүлэлт бүрийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг “Хаалттай” (0-40), “Зарим талаар ил тод” (41-60), “Ил тод” (61-80), “Бүрэн ил тод” (81-100) гэсэн 4 түвшнээр үнэлсэн.

2010-2018 оны индексийг дараах зурагт харуулав. Төрийн байгууллагуудын цахим ил тод байдал 2010-2014 онд “хангалтгүй” гэж үнэлэгдэж байсан бол 2015-2018 онд “зарим талаараа ил тод” гэж үнэлэгдсэн. Судалгааг хийж эхэлснээс хойш 2018 оныг хүртэл энэ үзүүлэлт 35 хувиар сайжирсан ч 2017 оны үзүүлэлтээс хоёр хувиар буурсан байна.

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс, оноор




2019 оноос “Цахим ил тод байдлын индекс” болгон аргазүйг шинэчилж, 1) Эрх зүйн орчин, 2) Байгууллагын чадамж, 3) Цахим нээлттэй байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгт багтах 9 дэд бүлэг, 26 үзүүлэлтийг 0-1 оноогоор “Сайн” (≥ 0.80), “Хангалттай” (0.65-0.79), “Сул” (0.50-0.64), “Хангалтгүй” (0.35-0.49), “Муу” (< 0.35) гэсэн 5 түвшинд үнэлдэг болсон.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023


2019 оны судалгаанд 72, 2020 оны судалгаанд 86, 2021 оны судалгаанд 88, 2022 оны судалгаанд 93 байгууллага хамрагдсан бөгөөд сүүлийн 4 жилийн судалгааны дунджаар төрийн байгууллагын цахим ил тод байдал “Сул” үнэлгээтэй байна:

Цахим ил тод байдлын индекс, оноор



2021 оны судалгаанд хамрагдсан 88 байгууллагын хувьд 28 хувь нь л “Хангалттай”, харин 62 хувь нь “Сул” үнэлэгдсэн байна:


Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



2.14 АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЗАРИМ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ


- Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2012-2023 онд шалгагдсан эрүүгийн хэрэг болон тэдгээр хэрэгт холбогдогчийн талаарх тоон мэдээллийг дараах зурагт үзүүлэв. Энэ хугацаанд нийт 9,756 хэрэгт 8,695 хүн холбогджээ:

2012-2023 онд Авлигатай тэмцэх газарт шалгагдсан эрүүгийн хэрэг болон тэдгээр хэрэгт холбогдогчийн тоо, оноор




- 2012-2023 онд Авлигатай тэмцэх газарт шалгагдсан эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг дараах зурагт үзүүлэв:

Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ (тэрбум төгрөг), оноор




- 2012-2023 онд 2,814.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 20.8 их наяд төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг), оноор



- 2023 онд Авлигатай тэмцэх газарт шалгагдсан нийт эрүүгийн хэргийн 11.5 хувь нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна:

Шалгагдсан болон шүүх ээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо, оноор




АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ – 2023


2012-2023 онд шалгасан нийт хэргийн тоотой харьцуулбал дунджаар 9.8 хувь (дээд тал нь 13.8 хувь /2014 он/, доод тал нь 5.2 хувь /2019 он/) нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

- Авлигатай тэмцэх газарт ирсэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл болон түүнийг шалгаж хариуцлага хүлээлгэсэн байдлын талаарх тоон мэдээллийг дараах зурагт үзүүлэв:

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн хяналт, шалгалт, оноор



Тухайн жилд хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн тоотой харьцуулбал дунджаар 6.8 хувьд (дээд тал нь 20.8 хувь /2015 он/, доод тал нь 3.8 хувь /2020 он/) нь хариуцлага хүлээлгэсэн байна.

The background features a dark blue gradient on the left side, transitioning to a lighter blue on the right. Several white paper arrows of varying sizes and orientations are scattered across the left side, pointing towards the right. A dark blue rectangular box is positioned in the center-right, containing white text. The box is framed by orange and teal L-shaped brackets.

**ГУРАВ.
АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 59

Төрийн ордон, Улаанбаатар хот

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 2¹.1 дүгээр зүйлийн 2¹.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Б.Энхбаяр/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2023–2030 он)

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдсан, 2023-2030 онд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

Зорилго 1. Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлнэ.

Зорилт 1.1. Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

1.1.1. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд сонгуулийн үеэр санал худалдан авахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал, журмыг боловсронгуй болгоно.

1.1.2. Сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөөгүй улс төрийн нам /цаашид “нам” гэх/, намуудын эвсэл /цаашид “эвсэл” гэх/, нэр дэвшигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулна.

1.1.3. Сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөөгүй нам, эвсэл, нэр дэвшигчид хүлээлгэсэн хариуцлагын талаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Зорилт 1.2. Сонгуулийн бус үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглоно.

1.2.1. Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд иргэдэд мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгө, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, эдгээрийг амлах, санал болгох зэрэг бүх төрлийн санал худалдан авах үйлдэл гаргахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.2. Төрийн улс төрийн албан тушаалтан иргэдийн саналыг авах зорилгоор сонгуулийн бус үед төрийн ажил, үйлчилгээг өөрийн нэрээр хэрэгжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаандаа татан оролцуулах, мөнгө, эд зүйл тараахыг хориглоно.

1.2.3. Сонгогчийн саналыг худалдан авахыг завдсан, худалдан авсан, сонгуулийн зардлын тайлангаа үнэн зөв гаргаагүй хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 1.3. Намын санхүүжилт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх замаар намын хариуцлага, ёс зүй, ил тод байдлыг сайжруулна.

1.3.1. Сонгуулийн жилийн санал хураалтын өдрөөс өмнө нам, бүх шатны сонгуульд нэр дэвшигчийн жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх, хэвлэн нийтлэх зэргээр сонгуулийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийг ил тод болгох журмыг боловсронгуй болгоно.

1.3.2. Намын санхүүжилтийг бүрэн ил тод болгож, хандив өгсөн этгээд, тэдгээрийн хандивын хэмжээ, түүнчлэн намын тайлагнасан зардлыг тусгасан жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг гаргуулдаг болно.

1.3.3. Намд хууль зөрчиж хандив өгсөн, авсан үйлдэлд хүлээлгэх хариуцлагын бодлогыг чангатгана.

1.3.4. Санхүүгийн тайлангаа санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгээгүй, эх үүсвэр нь тодорхойгүй санхүүжилт хүлээн авсан, балансын гадуур бүртгэсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг холбогдох хуульд тусган, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.5. Төрөөс намд олгосон санхүүжилтийг хүртээмжтэй болгож, Улсын Их Хуралд суудалгүй намуудыг төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, ашиг сонирхлын зөрчилтэй бүлэглэлийн нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.6. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх арга хэмжээ, төрийн худалдан авах ажиллагаа, хөнгөлөлттэй зээл, зээлийн баталгаа гаргуулсан аж ахуйн нэгж, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд, банк, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, уул уурхай, шатахууны импортын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс нам, эвсэл, нэр дэвшигч хандив авахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

1.3.7. Намын санхүүжилт /нам, түүний удирдлагаас хийсэн санхүүгийн шилжүүлэг/-ийг дотоодын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх дэглэмийн хүрээнд хамруулна.

Зорилт 1.4. Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ил тод болгож, сонгуулийн зардлыг бууруулан иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаалах, нэр дэвшигчийг өрсөлдөх тэгш боломжоор хангана.

1.4.1. Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч нь санал хураалтын өдрөөс өмнө санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хүргүүлэх, нийтэд мэдээлэх журмыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2. Сонгуулийн санхүүжилт, зардлын тайлан гаргах, нийтэд мэдээлэх журам зөрчсөн этгээдэд хариуцлага тооцсон тухай олон нийтэд ил тод мэдээлнэ.

1.4.3. Гадаад улсад байгаа иргэдийг сонгуульд оролцуулах, санал авах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.4.4. Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлыг бууруулна.

1.4.5. Иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэн иргэд, сонгогчдын хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

1.4.6. Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын аудитлагдсан санхүүгийн тайланд төрийн бус байгууллага, сонгогчоос хөндлөнгийн хяналт хийх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Зорилт 1.5.Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх /лоббидох/ эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

1.5.1.Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, үйл ажиллагааг ил тод болгоно.

1.5.2.Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшдэг хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.5.3.Улс төрд нөлөө бүхий этгээд болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн орлого, зарлага, татвар төлөлтийг хянах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Зорилго 2.Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.

Зорилт 2.1.Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

2.1.1.Төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ялгамжтай байдлыг арилгаж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

2.1.2.Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим системийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.1.3.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх болон бусад сургалтын давтамж, агуулгыг шинэчилж, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, хүний эрхийн үзүүлэлт, үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийн эрсдэлийг таних чадавхыг бэхжүүлж, олон улсын нийтлэг шаардлага /цаашид “Комплаенс” гэх/-ыг хангана.

2.1.4.Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад цогц чадамжийн шалгуурыг нэвтрүүлэх замаар чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ.

2.1.5.Төрийн албаны журам, стандарт, менежментийг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар төрийн албан хаагчийн ёс зүйг төлөвшүүлнэ.

2.1.6.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой төрд учруулсан хохирлын бүртгэл, хяналтын нэгдсэн системийг бий болгож, хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 2.2.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно.

2.2.1.Төсвийн захирагчаар томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахад олон нийтийг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.2.2.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Зорилт 2.3.Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.

2.3.1. Нийтийн албан тушаалтан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хуульд нийцүүлэн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтад нэмэлт, өөрчлөлт оруулна.

2.3.2. Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд төрийн байгууллагын мэдээллийг бүрэн ашиглаж, эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлнэ.

2.3.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөр хариуцлага хүлээсэн албан тушаалтны үйлдэл, хүлээлгэсэн хариуцлагын талаар олон нийтэд нээлттэй болгох эрх зүйн орчныг бий болгоно.

2.3.4. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын хяналт шалгалтын үр дүнд сонгуульд албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Зорилт 2.4. Төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.4.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд төрийн улс төрийн албан тушаалтан болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч томилогдохыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.4.2. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улс төрд нөлөө бүхий этгээдэд албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш тогтоосон хориглолт, хязгаарлалтын хугацааг шинэчлэн тогтооно.

2.4.3. Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлана.

Зорилт 2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.

2.5.1. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.

2.5.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулна.

2.5.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хянах нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, хоёр жил тутамд хяналт шинжилгээ хийнэ.

Зорилт 2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.

2.6.1. Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж, үнэлгээ хийнэ.

2.6.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.

Зорилго 3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.

Зорилт 3.1. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ, бүтцийг олон улсын жишиг, сайн туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжийг үндэслэн оновчтой тодорхойлж, олон нийтийг төлөөлөх боломж, нөхцөлийг хангасан эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

3.1.1. Олон нийтийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээг оновчтой тодорхойлно.

3.1.2. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн төсөв, орон тоог шинэчлэн тогтооно.

3.1.3. Олон нийтийн зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл явцыг нээлттэй, ил тод болгоно.

3.1.4. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланд Олон нийтийн зөвлөлийн санал, зөвлөмжийг тусгана.

Зорилт 3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.

3.2.1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоог хангах арга хэмжээг эрчимжүүлнэ.

3.2.2. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ иргэний нийгмийн байгууллагын санал, дүгнэлтийг авах замаар тэдгээрийн оролцоог хангах арга хэмжээг хэвшүүлнэ.

3.2.3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонголын тухай хуульд заасан сонголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.4. Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгож, иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

Зорилт 3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.

3.3.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.

3.3.2. Хүний эрх, засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад иргэний хандив, тусламж авах замаар хараат бус санхүүжилт босгох арга зам, холбогдох хариуцлагын зохицуулалтыг бий болгоно.

3.3.3. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын Техник хэрэгжилтийн зөвлөмжид нийцүүлэн ашгийн бус салбар дахь терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, үүнд ашгийн бус байгууллагыг хамруулна.

Зорилт 3.4. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

3.4.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно.

3.4.2. Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл

мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

3.4.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ.

3.4.4.Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Зорилго 4.Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.

Зорилт 4.1.Бизнесийн ёс зүй, Комплаенсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.1.1.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид авлигын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах болон Комплаенсыг нэвтрүүлэхэд арга зүйн удирдамжаар хангана.

4.1.2.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид сайн дурын үндсэн дээр бизнесийн ёс зүй, Комплаенсыг нэвтрүүлэх, авлигын, мөнгө угаах, эдийн засаг, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.1.3.Компанийн ёс зүйн дүрэм, журамд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ.

Зорилт 4.2.Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.

4.2.1.Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

4.2.2.Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох суурь судалгааг үе шаттайгаар зохион байгуулж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.2.3.Эдийн засаг, татварын өршөөл үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчинд иж бүрэн дүн шинжилгээ хийж, өршөөлд хамрагдсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг өршөөлд хамруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.4.Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангана.

4.2.5.Арбитрын чадавхыг бэхжүүлж, шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг нэмэгдүүлэх нөхцөлийг дэмжиж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Зорилт 4.3.Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.

4.3.1.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй болгоно. Мэдээлэл ирүүлээгүй хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгана.

4.3.2.Компанийн нийгмийн хариуцлагын стандартыг нэвтрүүлнэ.

Зорилго 5. Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна.

Зорилт 5.1. Авлигатай тэмцэх газрын төсөв, санхүү, хүний нөөцийн чадавхыг сайжруулах цогц арга хэмжээг авч олон улсын жишигт хүргэнэ.

5.1.1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг чадавхжуулах, хүний нөөцийг бэхжүүлэх стратеги боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.1.2. Авлигатай тэмцэх газрын удирдлагыг томилох, чөлөөлөхөд улс төрөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.1.3. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын орон тоог үйл ажиллагааны онцлог, ажлын ачааллыг харгалзан нэмэгдүүлнэ.

5.1.4. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалт, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг тодорхойлох, авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон холбогдох мэдээлэл, их өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ, боловсруулалт хийх чиг үүрэг бүхий төвийг байгуулна.

5.1.5. Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.6. Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлыг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.1.7. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг бэхжүүлнэ.

5.1.8. Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, цахим орчинд шинжилгээ хийх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэрч, хохирогч, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна.

Зорилт 5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.2.1. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийж, авлигын эсрэг үйл ажиллагааг өргөжүүлнэ.

5.2.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.2.3. Авлига, ашиг сонирхлын зөрчил болон сахилга, ёс зүйн зөрчилд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгоно.

Зорилт 5.3. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлнэ.

5.3.1. Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр шүүгчийг мэргэшүүлж, орон тоог үйл ажиллагааны онцлог, ажлын ачааллыг харгалзан нэмэгдүүлнэ.

5.3.2. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, хэрэг, зөрчлийг шийдвэрлэж байгаа олон улсын туршлага, практик үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, мэргэшсэн шүүгчийг бэлтгэнэ.

5.3.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, прокурор, шүүхийн шийдвэр, шийдвэр

гүйцэтгэх ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлэх тогтолцоог бий болгоно.

5.3.4. Авлига, албан тушаалын гэмт хэрэг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх агуулга, хөтөлбөрийг шүүгчийн давтан сургалтад нэвтрүүлнэ.

Зорилт 5.4. Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлнэ.

5.4.1. Прокурорын сахилга, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоог шинэчлэх замаар хариуцлагыг нэмэгдүүлнэ.

5.4.2. Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр прокурорыг мэргэшүүлж, бүтэц, орон тоог олон улсын жишигт нийцүүлнэ.

5.4.3. Олон улсын авлигын эсрэг сүлжээ, гадаад хамтын ажиллагаа, туршлага судлах үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газар, прокурорын оролцоог нэмэгдүүлж, шаардлагатай нөхцөл, боломжоор хангана.

5.4.4. Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэхжүүлнэ.

Зорилт 5.5. Авлигын эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлнэ.

5.5.1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хийх бүтээн байгуулалтын ажлын төсөв, санхүү, зарцуулалт, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих нөхцөл, боломжийг бүрдүүлж, үүсэж болзошгүй авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

5.5.2. Авлигын эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг олон нийтэд мэдээлнэ.

5.5.3. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон суурь гэмт хэргийг шалгах аргачилсан зааврыг боловсруулан үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

Зорилт 5.6. Авлигатай тэмцэхэд төрийн аудитын байгууллагын үр нөлөөтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.

5.6.1. Авлигатай тэмцэх газар болон төрийн аудитын байгууллагын авлигын эсрэг чиглэсэн хамтын ажиллагааг төлөвшүүлэх, талуудын үүрэг, оролцоог оновчтой тодорхойлж, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

5.6.2. Төрийн аудитын байгууллагын улс төрөөс хараат бус, ил тод, бие даасан байдлыг бэхжүүлнэ.

5.6.3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын үр дүнг ашиглах горим, тогтолцоо бий болгоно.

Зорилго 6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Зорилт 6.1. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана.

6.1.1. Хөрөнгө буцаасан, мэдээлэл солилцсон, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан олон улсын туршлагад тулгуурлан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

6.1.2. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 46 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад дамжуулах асуудлыг хариуцсан эрх бүхий төв байгууллагыг томилох, 49 дүгээр зүйлд заасны дагуу хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

6.1.3. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 46 дугаар зүйлд заасны дагуу хүсэлт илгээх, хүлээн авах, мэдээлэл, нотлох баримт солилцох, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзах, хүсэлт гүйцэтгэхтэй холбогдсон зардалтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчныг тодорхой болгоно.

6.1.4. Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.1.5. Авлигын гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлж тодорхойлно.

6.1.6. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 17 дугаар зүйлд заасан “албаны эрх нөлөөг урвуулан ашиглах” үйлдлийг гэмт хэрэгт тооцдог болох эрх зүйн орчныг бий болгоно.

6.1.7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийг хангаж, эрүү шүүлт тулгах, нотлох баримт хуурамчаар үйлдэх гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлно.

6.1.8. Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.

6.1.9. Хуулийн этгээд, нийтийн албан тушаалтнаас хууль бус давуу байдал олж авсан үйлдлийг гэмт хэрэгт тооцох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.1.10. Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлнэ.

6.1.11. Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

6.1.12. Мөрдөн шалгах ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглаж мэдүүлэг авах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.1.13. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 12.4 дүгээр заалт /хахуульд өгсөн зардал болон зохих тохиолдолд авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох зардлаас хасаж тооцохыг үл зөвшөөрнө/-ыг холбогдох татварын хууль тогтоомжид тусгана.

6.1.14. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг хангаж, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.

6.1.15. Банк, санхүүгийн байгууллагаас бусад байгууллагаар мөнгөн гүйлгээний хэрэгсэл ашиглах, сүлжээ ашиглах болон хавала зэрэг санхүүгийн гэмт хэргийн шинээр илрэх хэлбэрийг оновчтой хянах тогтолцоог эрсдэлийн үнэлгээнд суурилж бэхжүүлнэ.

Зорилт 6.2. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.

6.2.1. Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх, хөрөнгө буцаах, мөнгө угаахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

6.2.2. Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн зөрчлийг илрүүлэх чиглэлээр бусад улс орны хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллана.

6.2.3. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны явцад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг үр дүнтэй явуулах нөхцөл байдлыг хангах, мөрдөгч нарыг мэргэшүүлэх, гадаад хэлний мэдлэг, бусад ур чадварыг эзэмших нөхцөл, боломжийг бий болгоно.

6.2.4. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон боловч хуулийн байгууллагад шалгуулалгүйгээр оргон зайлсан, гадаад улсад байгаа нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан этгээдийг Монгол Улсад буцаан авчирч гэм буруутай эсэхийг нь шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бататгана.

6.2.5. Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.

Зорилт 6.3. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ.

6.3.1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.3.2. Оффшор бүс, гадаад улсаас шилжүүлэн авсан хууль бус хөрөнгө, орлого, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх явцад хураасан хөрөнгийг нээлттэй, ил тод байдлаар зарцуулах тогтолцоог бий болгоно.

6.3.3. Нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө буцаах болон захиран зарцуулах нөхцөл, журам, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Зорилт 6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

6.4.1. Орлогоосоо давсан зарлагатай, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ нотолж чадаагүй албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөх, эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.4.2. Авлигын гэмт хэрэгт үгсэн тохиролцож, хууль бусаар давуу байдал олж авсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгоно.

6.4.3. Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох замаар шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ.

6.4.4. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг цахим санд байршуулах замаар шийдвэрийн ил тод байдлыг бий болгоно.

6.4.5. Авлигын гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын гуравны хоёр хувийг биеэр эдлээгүй ялтныг шүүхийн магадлалаар хугацаанаас өмнө суллахгүй байх зохицуулалтыг хуульд тусгана.

6.4.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой болгоно.

6.4.7. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн мэдээллийг ил тод болгох эрх зүйн орчныг сайжруулна.

6.4.8. Хэвлэл мэдээллийн байгууллагын эцсийн өмчлөгч болон санхүү, орлогын эх үүсвэрийн талаарх мэдээллийг ил тод болгох зохицуулалтыг сайжруулна.

6.4.9. Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг шалгах аргачлал болон гарын авлагыг боловсруулж, хуульч, хууль сахиулагчид хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх нөхцөл, бололцоог бүрдүүлнэ.

6.4.10. Тусгай субъектийн үйлдсэн авлигын гэмт хэргийг шалгах чиг үүргийг дангаар хариуцсан нэгжийг бий болгоно.

6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.

Зорилго 7.Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.

Зорилт 7.1.Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.

7.1.1.Төсвийн төслийн баримт бичигт өрийн бүтцийн мэдээллийг дэлгэрэнгүй тусгаж, эдийн засгийн өсөлтийн төсөөлөл төсөвт үзүүлэх нөлөөллийн мэдээллийг тодорхой болгон тооцооллын тоон мэдээллийг нээлттэй өгөгдлийн зарчмаар нийтэлнэ.

7.1.2.Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв захирагчдаар нийтлэхээс гадна эдийн засгийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.

7.1.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангана.

7.1.4.Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний эрэмбийг тогтоох, хөрөнгө оруулалтын дэд бүтэц, уул уурхай, бүтээн байгуулалтын төслийг төлөвлөхдөө техник, эдийн засгийн үндэслэл, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, зардлын тооцоололд суурилсан эсэхийг хянах тогтолцоог бүрдүүлж, олон нийтэд ил тод болгоно.

7.1.5.Төсвийн гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах үед төсвийн захирагчдын хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлтийг үнэлж, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

7.1.6.Төсөвт бус зардлыг төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөөс татах, төлүүлэх, өр барагдуулах зэргээр төсвөөс гадуурх зардал гаргахыг хориглох, хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.1.7.Хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн аргыг хэрэглэхээс гадна гүйцэтгэлд суурилсан, хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй, аккруэл суурьт төсөвлөлтийн аргуудыг хэрэглэж хэвшинэ.

7.1.8.Төсөвлөлт, тайлагналын кодчиллол, ангиллыг нэгтгэн гүйцэтгэлд суурилсан төсвийг хянах системийг нэвтрүүлж, төсвийн ангилал, зориулалт, санхүүжилтийн зүйл тус бүрээр блокчейн кодчиллол бий болгож, төсөвт төсөл, арга хэмжээг өөр нэршил, зориулалт, ангиллаар давтагдах, давхардуулж төсөвлөх байдлыг таслан зогсооно.

7.1.9.Гүйлгээнд бэлэн бус төлбөр тооцооны эзлэх хувийг нэмэгдүүлж, төсвийн орлогын суурийг өргөжүүлж, далд эдийн засгийн эзлэх хэмжээг багасгах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.10.Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулж хэвшинэ.

7.1.11.Төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж байгаа эсэхэд төрийн аудитын байгууллага дүгнэлт гаргадаг үйл ажиллагааг тогтмол болгоно.

Зорилт 7.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, дуудлага худалдааг нээлттэй, боловсронгуй болгож, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

7.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, удирдлагын нэгдсэн систем бий болгож, хөрөнгийн хөдөлгөөн, засвар үйлчилгээний зардал, хөрөнгө оруулалтын зардлыг нэгтгэж хянах боломжийг бүрдүүлнэ.

7.2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тооллого, түрээсийн сонгон шалгаруулалт, худалдан авалтын нэгдсэн бүртгэлийг боловсронгуй, нээлттэй болгох, дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлж, олон нийтийн бодит оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

7.2.3.Төрийн өмчийн биет бус, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг олон улсын стандартын дагуу гүйцэтгэж, данснаас хасагдсан хөрөнгийн үнэлгээг бодитой болгож, хөрөнгийг үр ашигтай зарцуулах нөхцөл, бололцоог нэмэгдүүлж, эрх зүйн орчныг сайжруулна.

7.2.4.Хөрөнгийн дуудлага худалдааны дүрэм, журмыг олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн орчныг сайжруулна.

Зорилт 7.3.Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

7.3.1.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, төсөл сонгон шалгаруулалт, зарцуулалтыг ил тод, олон нийтийн хяналттай, хариуцлагатай болгож, олон улсын жишигт нийцүүлнэ.

7.3.2.Засгийн газрын тусгай сангийн хэрэгцээ, шаардлага, хуримтлал, удирдлага, зарцуулалтыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгоно.

7.3.3.Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох, эрсдэлийн үнэлгээг тодорхой хугацаанд давтамжтай хийж, аудитын үр дүнгээр нийтийн сонсгол зохион байгуулна.

7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

7.3.5.Гадаадын зээл, тусламжийн санхүүжилттэй төслүүдийн нэгдсэн төлөвлөлт, бүртгэл, хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг олон нийтэд ил тод болгоно.

7.3.6.Гадаадын зээл, тусламжийн бүртгэлийг төрийн санхүүгийн удирдлагын системд нэгтгэж, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулна.

Зорилт 7.4.Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

7.4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.

7.4.2.Ерөнхий гэрээгээр худалдан авах барааны нэр төрлийг нэмэгдүүлэх, шууд худалдан авалт зохион байгуулах журам, аргачлал, шалгуурыг тодорхой болгож мөрдүүлнэ.

7.4.3.Худалдан авах ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулна.

7.4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан төлөвлөж, ил тод байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг бэхжүүлнэ.

7.4.5.Төрийн худалдан авах ажиллагааны гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг тусгах, зөрчил тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлүүлж, олон нийтэд мэдээлнэ.

Зорилт 7.5.Төрийн аудит, дотоод аудитын тогтолцооны хараат бус, ил тод, бие даасан байдлыг бэхжүүлнэ.

7.5.1.Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллагыг иргэний нэхэмжлэгчээр тогтоох зохицуулалтыг хуульчилна.

7.5.2.Төрийн аудитын тухайн жилийн сэдвийн төлөвлөлт, аудитын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж, эргэх холбоо тогтоох нөхцөлийг бүрдүүлнэ.

7.5.3.Засгийн газрын хяналт шалгалт, төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгоно.

7.5.4.Аудитын хуулийн этгээдийг төрийн аудитад татан оролцуулах үйл ажиллагааг ил тод болгож, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

7.5.5.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгоно.

Зорилго 8.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 8.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын томилгоог ил тод болгож, олон улсын хөрөнгийн зах зээлийн нээлттэй компанийн жишигт нийцсэн хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

8.1.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ил тод байдал, хяналт, хариуцлагын стандартыг нээлттэй компанид мөрдөгдөж байгаа олон улсын жишигт хүргэнэ.

8.1.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах

зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, сонгох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, шударга, нээлттэй, ил тод, хөндлөнгийн оролцоогүйгээр өрсөлдөх боломжийг хангана.

8.1.3.Компанийн эрх бүхий албан тушаалтантай байгуулах гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хүрэх үр дүнг нарийвчлан зааж, ажлын гүйцэтгэлийн шалгуурыг хэмжигдэхүйц байдлаар тогтоож, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, хохирол барагдуулах нөхцөлийг баталгаажуулна.

8.1.4.Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин хөлс, урамшуулал, тэтгэмж, дэмжлэг ил тод байх тогтолцоог бүрдүүлнэ.

8.1.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг бий болгоно.

8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттайгаар бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.

Зорилт 8.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг завших, үрэгдүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

8.2.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Компаенсын тогтолцоог нэвтрүүлнэ.

8.2.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг үйл ажиллагааны үндсэн зорилгод нийцээгүй улс төрийн шинжтэй шийдвэр, нийгмийн халамж, тусламж дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал зэрэг үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулахыг таслан зогсооно.

8.2.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн баталгаажсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг олон нийтэд ил тод байх нөхцөлийг бүрдүүлнэ.

8.2.4.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбогдсон үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоно.

Зорилт 8.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг холбогдох тооцоо, судалгаа, зардал, үр ашгийн тооцоонд үндэслэн үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцэд өөрчлөлт оруулах шалгуур, шаардлага, журмыг боловсронгуй болгоно.

8.3.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани, түүний охин компанийг үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийхэд мөнгөн урсгал, техник, эдийн засгийн үндэслэл, улсын төсөвт төвлөрүүлэх татвар болон судалгаа, дүн шинжилгээнд тулгуурладаг байна.

8.3.2.Алдагдалтай ажилласан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын шалгалт хийж, үндэслэл, шалтгааныг тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зорилт 8.4.Байгалийн баялгийн орлого, үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, иргэнд тэгш, шударга хүртээнэ.

8.4.1.Үндэсний баялгийн сангийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны ил тод байдал, зарцуулалт, үр өгөөж, хяналт, хариуцлагыг олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

8.4.2. Байгалийн баялгийн орлогоос бүрдсэн сангуудын хуримтлал, зарцуулалтад дүн шинжилгээ хийж, үр ашиг, үр нөлөөг олон нийтэд ил тод болгож, нийтийн сонгол зохион байгуулна.

8.4.3. Төрийн болон орон нутгийн өмчит, хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ногдол ашгийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлнэ.

8.4.4. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Зорилго 9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.

Зорилт 9.1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн дэвшил, судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ.

9.1.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ.

9.1.2. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх арга зүйг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

9.1.3. Амьдралын хэв маяг, үзэл бодол, үнэт зүйлс, соёлд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

9.1.4. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, цахим платформыг судалж, нэвтрүүлнэ.

9.1.5. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөлийг судлах, эрсдэл тодорхойлох, хяналт тавих ажлыг иргэний нийгэм, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, оролцоог нэмэгдүүлнэ.

Зорилт 9.2. Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.

9.2.1. Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ.

9.2.2. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.

Зорилт 9.3. Ёс суртахуун, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрийг олон улсын туршлагад тулгуурлан шинэчлэлт, үнэлгээ хийж хэвшүүлнэ.

9.3.1. Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг олон улсын туршлага, үндэсний онцлогт нийцүүлэн тусгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлнэ.

9.3.2. Эрсдэлд суурилсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

9.3.3. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

Зорилт 9.4. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.

9.4.1. Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.

9.4.2. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно.

9.4.3. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.4.4. Боловсролын сургалтын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээг зохион байгуулж хэвшинэ.

Зорилт 9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.

9.5.1. Төрийн албан хаагч болон удирдах албан тушаалтанд авлигын эсрэг сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, ёс зүй, манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.

Зорилт 9.6. Авлигын эрсдэлтэй үйл ажиллагаа, салбарын онцлог, нөхцөл байдалд чиглэгдсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тооцож хэвшинэ.

9.6.1. Сонгогчийн боловсрол, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын сүлжээ үүсгэн, хамтын ажиллагааг өргөжүүлж, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Зорилго 10. Гамшгаас хамгаалах, онц байдлын үеийн үйл ажиллагаа болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлнэ.

Зорилт 10.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах тусгайлсан бодлого, хөтөлбөр, тогтолцоог бий болгоно.

10.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

10.1.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Зорилт 10.2. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн мөрөөр авч хэрэгжүүлэх хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

10.2.1. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед худалдан авах ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нээлттэй, ил тод зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

10.2.2. Стратегийн нөөц, батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийн худалдан авалт, зарцуулалтыг нууцаас гаргах, ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

10.2.3. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.

10.2.4. Мөнгөн хандивыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулалтыг тухай бүр олон нийтэд ил тод тайлагнана.

10.2.5. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнд Авлигатай тэмцэх газрын төлөөллийг ажиллуулна.

10.2.6. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед тусгай үүрэг гүйцэтгэн ажиллах байгууллагын авлигын эрсдэлийг тодорхойлж, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт 10.3. Ирээдүйд тулгарч болзошгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.

10.3.1. Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулж, бэлэн байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

10.3.2. Хүний нөөцийн дутагдалтай, ирээдүйд дутагдалд орж болзошгүй ажил, мэргэжлийг судалж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

10.3.3. Шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх байдлаар авлигын эрсдэлийг тодорхойлдог болно.

Зорилго 11. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулна.

Зорилт 11.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

11.1.1. Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Монгол Улсын Засгийн газар хариуцан ажиллана.

11.1.2. Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүрэг бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын алба ажиллана.

11.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хариуцсан байгууллага хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлнэ.

11.1.4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

11.1.5. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно.

